

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY



Агуулахын бизнес эхлүүлэгчдэд
өгөх санаа


Үг биш үйлдэл харуулна

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 11 сар. №22 (032)

www.mongolianeconomy.mn

ГЕРМАНЫ ТУРШЛАГА МОНГОЛД



УУЛ УУРХАЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ӨРГӨТГӨЛӨӨ.



Вагнер Ази компани Монгол дахь Бисайрус Дистрибьютерийн Бизнесийн эзэмших эрхийг бүрэн авлаа

Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК нь Монгол улсад Бисайрусын түгээлт, дэмжих бизнесийн эрхийг Катерпиллар Глобал Майнинг ХХК-аас бүрэн өөртөө авах шилжилтийн үйл ажиллагааг 2012 оны 11-р сарын 01-ны өдөр бүрэн дуусгалаа.

“Бисайрусын бүтээгдэхүүний хүрээг нэмснээр уул уурхайн салбарын тоног төхөөрөмжийн хамгийн өргөн хүрээг бий болгон Уул уурхайн компанийн харилцагчид, ил, далд уурхай, нүүрс ба чулуулгийн уул уурхайн бүхий л тоног төхөөрөмжийн хэрэгцээ, борлуулалтын дараах үеийн бүрэн үйлчилгээг Монгол дахь шилдэг хамт олон, чанартай багаж хэрэгсэл, олон салбар бүхий 16 жилийн туршлагатай компаниас авах болно” гэж Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК-ны Ерөнхий захирал Стив Поттер ярьж байна.

Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК-нь 1996 оноос хойш КАТ-ын тоног төхөөрөмжийн дилерийн үйлчилгээ болох худалдаа, түрээс, бүтээмжийг дээд зэрэгт хүргэх тоног төхөөрөмж, хөдөлгүүрийн засвар үйлчилгээгээр харилцагчидаа дэмжин ажиллаж ирсэн, Улаанбаатар хотод төвтэй Монгол Улсын бүхий л нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа томоохон компани билээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

Б.Баттөр

Худалдааны хэлтсийн захирал

Tel: 976-11-687588



www.wagnerasia.com

WAGNER
ASIA EQUIPMENT LLC





ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

300 САЯ АМ.ДОЛЛАРЫН БОНД



3 дахь удаагаа олон улсын зах зээлд АМЖИЛТАЙ АРИЛЖААЛЛАА

хугацаа 3 жил
жилийн хүү 8.5%

Европийн дунд хугацааны үнэт цаасны
700 сая ам. долларын хөтөлбөрийн хүрээнд

Хамтарсан андеррайтер:



Төлбөр гүйцэтгэгч агент:



Хамтран зохион байгуулагч:



Bloomberg

TV MONGOLIA

ВЛООМБЕРГ МЕДИА ГРУППТЭЙ ХАМТРАН

2012 ОНЫ 10-Р САРД АМЖИЛТАЙ НЭЭЛЭЭ



МОНГОЛ УЛСЫН
ШИЛДЭГ БАНКААР
ШАЛГАРЛАА



МОНГОЛ УЛСЫН
ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТЫН
ШИЛДЭГ БАНКААР
ШАЛГАРЛАА

(976-11) 1977

info@tdbm.mn

www.tdbm.mn



DHL GLOBAL FORWARDING

Агаарын болон далайн ачаа тээвэрлэлт, аж үйлдвэрийн ба төслийн тусгай ачаа тээвэрлэлтэд бид дэлхийд тэргүүлэгч юм

Монгол дахь салбар 2005 онд "DHL Global Forwarding" төлөөлөгчийн газраас "DHL Global Forwarding" нэртэй тээвэр зуучийн компанийг нээх эрх олгогдон үйл ажиллагаагаа явуулж байна.

**195 ЖИЛИЙН ТҮҮХТЭЙ
ДЭЛХИЙН 220 ГАРҮЙ ҮЛСАД**

30.000 ажиллагсад

72.000 тээврийн хэрэгсэл

820 терминал

400 онгоц

70 гаруй өндөржүүлсэн хамгаалалттай газрууд

20.000-с дээш чиглэлд



Бид танд дараах үйлчилгээг санал болгож байна

Бүх төрлийн Экспортын ачаа
Бүх төрлийн Импортын ачаа
Жижиг дунд үйлдвэрлэлийн төслийн ачаа
Тусгай ачаа
Аж үйлдвэрийн ачаа
Түүвэр ачаа
Холимог ачаа
Нисэх буудлаас нисэх буудалд
Хаалганаас хаалганд

Бид танд дараах баталгааг гаргаж өгнө

Өндөр хүчин чадал
Боломжийн үнэ
Найдвартай
Шуурхай үйлчилгээ
Чадварлаг хамт олон
Таны хүсэлд нийцүүлэн даатгалд хамруулах гэх мэт



Хаяг: DHL компанийн байр,
Энхтайваны өргөн чөлөө 10/5
Улаанбаатар-14210
Монгол Улс

Утас: 976-70114458
976-70114454
Факс: 976-70115558

И-мэйл: dgf.mongolia@dhl.com
Вэб: <http://www.dhl.com>

COAL MONGOLIA 2013

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 3 ДАХЬ
УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

2013 оны 2 сарын 21-22

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, SS CONVENTION CENTER

Чуулга уулзалт, үзэсгэлэн нь Монгол Улсад хэрэгжүүлж буй нүүрсний хайгуул, олборлолт, боловсруулалтын төслүүдэд хөрөнгө оруулалт татах, нүүрсний салбарт төрөөс баримтлах бодлогыг танилцуулах, байгаль орчинд ээлтэй, шинэ дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, олон улсын харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж Монгол Улсын нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой.



БҮРТГЭЛ ЭХЭЛЛЭЭ

Хуралд
нэгдүгээр сарын
15-наас өмнө
бүртгүүлбэл
20%
хөнгөлөлттэй

Үзэсгэлэнд
арванхоёрдугаар
сарын 15-наас өмнө
бүртгүүлбэл
5%
хөнгөлөлттэй

Platinum sponsor

Diamond sponsor

Gold sponsor

Bank of the event

Event sponsor



Supporting organizations

International media partners

Local media partners



Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.coalmongolia.mn, +976-70115590

Зохион байгуулагч



Ногоон хөгжлийн пөлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ: Ж.Түмэнбаяр

СЭТГҮҮЛЧИД: Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Б.Ууганбаяр

Х.Хулан

Б.Үүрийнтуяа

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав /8880-0825/

Д.Баттулга /9902-2279/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш

"ECONOMY" ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ:

Ц.Буянбат /8811-2885/

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН

Г.Буянбаатар

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

"MONGOLIAN ECONOMY"

ЦАХИМ ХУУДСААР ТАНЫ ОЮУНД

www.mongolianeconomy.mn

Хариуцлагатай бизнес л дэлхийн зах зээлд хүрдэг



Хатагтай Сабинэ Мюллер нь Германы Франкфурт хотноо төрж өссөн, гурван ахтай өнөр бүлийн гишүүн. Тэрбээр багаасаа л гадаад оронд амьдарч, ажиллах сонирхолтой байжээ...8

Стандартлаг дэлхий

...Сургалт, эмнэлгийн үйлчилгээ, хүнсний аюулгүй байдал, хот төлөвлөлт гээд бүх зүйл стандарттай. Тэр стандартад л нийцүүлж чадахгүй бол Европын холбоо хүлээж авахгүй “бака, чау” гэнэ...18



Уламжлал шинэчлэлийн аль нь вэ



...Махны технологи, үйлдвэрлэл өндөр хөгжсөн Герман улсад хувийн мал, амьтантай фермерүүд манайхан шиг хүссэн үедээ сүргээсээ дураараа нядлах эрхгүй...30

Компани+Төр+Иргэн= Хариуцлага

...Компанийн нийгмийн хариуцлага зөвхөн уул уурхай бус, бизнесийн бүхий л салбарт хамааралтай. КНХ-ын асуудал Монгол улсад хөгжих үйл хэдийнэ өрнөсөн бөгөөд даяаршсан ертөнцөд ухрах зам байхгүй...36



ЭДИЙН ЗАСАГ

- 8 Харилцаа тогтооё, харилцан суралцъя, хамтдаа хөгжье
- 9 Хариуцлагатай бизнес л дэлхийн зах зээлд хүрдэг
- 12 Агуулахын бизнес эхлүүлэгчдэд өгөх санаа
- 14 Логистик, кластер, инноваци...
- 16 Хөрсөндөө зориулж үрээ суулгах хэрэгтэй
- 18 Стандартлаг дэлхий
- 20 Уламжлал шинэчлэлийн аль нь вэ
- 24 Газрын тосоор дэлхийг эзлэх үү
- 26 Үг биш үйлдэл харуулна
- 28 Герман-Монголын эдийн засгийн харилцааны байдал, хөгжлийн боломж

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

- 32 Хэмнэж, гамнах ухаан

БИЗНЕС

- 34 Компани+Төр+Иргэн= Хариуцлага
- 36 “Хүний хөгжил орхигдох ёсгүй”
- 40 Сайн засаглалын хөрс ТУЗ

ОНЦЛОХ

ХАРИЛЦАА ТОГТООЁ, ХАРИЛЦАН СУРАЛЦЪЯ, ХАМТДАА ХӨГЖЬЕ

И.ОТГОН

“Техникийн туслалцаа үзүүлэх, ноу–хау нэвтрүүлэх талаарх Монголын эрэлт хэрэгцээ бидний хийж чадах хэр хэмжээнээс хавьгүй илүү байгаа нь анзаарагддаг” хэмээн Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /ГОУХАН/-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Сабинэ Мюллер манай сэтгүүлд өгсөн сонирхолтой ярилцлагадаа дурьджээ.

Тиймээ, Монгол улсын хурдацтай хөгжил монголчуудаас шинэ сэтгэлгээ шаардаж, зэх зээлийн шинэ шинэ эрэлт хэрэгцээг бий болгож, тогтвортой хөгжлийг даллаж буй билээ. Энэхүү эрэлт хэрэгцээг хангахын тулд бидэнд өндөр хөгжсөн орнуудын туршлагаас суралцаж, сорилтын өмнө урт замыг туулах биш, цаг хугацааг товчлон шинэ хөгжилд хүрэх хаалга цэлийтэл дэлгээстэй байгаа нь том боломж юм. Газрын хэвлийн баялаг, эдийн засгийн өндөр өсөлтөөрөө дэлхийд гайхуулж буй Монгол улстай хамтарч ажиллах, хүрсэн амжилт ололтын туршлагаасаа хуваалцах сонирхолтой орнууд ч олширч байгаа нь олзуурхууштай. Тухайлбал, ГОУХАН-ийн “Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөрөөс “Герман-Монголын бизнесийн өдрүүд” чуулга уулзалтыг өнгөрсөн сарын 22-24-нд “Харилцаа тогтооё, харилцан суралцъя, хамтдаа хөгжье” гэсэн уриатайгаар зохион байгуулсан. Уг хурал Монголд тулгамдаж буй асуудлууд болох Техник технологи, аж үйлдвэрийн шинэчлэл, Хангамжийн сүлжээний менежмент буюу Өсөж



Фотог Э.Зоригт

буй зах зээлд хэрхэн үйлчилгээ үзүүлэх вэ вэ, Компанийн нийгмийн хариуцлага гэсэн үндсэн сэдвүүдийн хүрээнд хүнсний хангамж, чанар, стандарт, сэргээгдэх эрчим хүч, мэргэжлийн боловсрол, хүний нөөц гээд олон салбарыг багтаасан билээ. Монголд шинэ тутам хөгжиж буй эдгээр салбаруудын хөгжлийн талаар Германы салбар салбарын эрдэмтэн, судлаач, бизнесийн төлөөлөл туршлага, мэдлэгээсээ харамгүй хуваалцсан. Гурван өдрийн турш оролцогчдын тоо 1000-аас буураагүй гэсэн зохион байгуулагчдын мэдээллээс үзэхэд монголчуудад өндөр технологи, чанартай боловсрол, логистикийн салбарын хөгжлөөр дэлхийд тэргүүлэгч германчуудаас суралцах хүсэл оргилон байгаа нь харагдах аж. Герман улс ч манайтай хамтын ажиллагаагаа шинэ түвшинд гаргахыг хүсэж, энэ чиглэлээр хоёр орны төр,

засгийн түвшинд ч сүүлийн хоёр жилд идэвхтэй хамтран ажиллаж байгаа билээ.

Бизнес, шинжлэх ухаан, төрийн болон төрийн бус байгууллага гээд өргөн хүрээний төлөөлөл оролцсон уг хурлын үеэр хөндөгдсөн олон шинэлэг сэдвээс бид гол гэснийг нь түүвэрлэн энэ удаагийн дугаартаа онцолж байна. Энэ удаа багтаагүй үлдсэн сонирхолтой сэдвүүд ч бий. Тэр талаар манайх дараа дараагийн дугаартаа гаргах болно. Хуралд оролцсон хоёр талын оролцогчдын зармынх нь сэтгэгдлийг сонирхоход “Герман-Монголын бизнесийнхэн анх удаагаа өргөн хүрээнд мэдээлэл солилцсон өндөр ач холбогдолтой уулзалт боллоо. Дараа дараагийн уулзалтаар улам их амжилт гарна гэдэгт итгэлтэй байна” хэмээж байсан. Тиймээ, Монгол-Герман хоёр улс бүх талаар харилцаа тогтоож, харилцан суралцаж, хамтдаа хөгжих биз ээ. ■

МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ҮГ

ХАРИУЦЛАГАТАЙ БИЗНЕС Л ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ХҮРДЭГ

Х.ХУЛАН

Хатагтай Сабинэ Мюллер нь Германы Франкфурт хотноо төрж өссөн, гурван ахтай өнөр бүлийн гишүүн. Тэрбээр багаасаа л гадаад оронд амьдарч, ажиллах сонирхолтой байжээ.

Хорь орчим жилийн өмнө Сабинэ Мюллер Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгт ажиллаж эхэлсэн бөгөөд тэр үеэс Бангладеш, Хятад, Шри Ланка, Африкийн Зимбабвед ажиллаж, амьдарч байжээ. Монголд ирэхийнхээ өмнө Герман улсын хамгийн нарлаг бөгөөд ногоон хот болох Фрайбургийн Альберт-Людвигийн нэрэмжит их сургуулийн багшийн ажлыг ГОУХАН-ийн албатайгаа хослуулан хийдэг байж. ГОУХАН-ийн Монгол дахь суурин төлөөлөгч хатагтай Мюллер гэр бүлийн хүнийхээ хамт 2010 онд Монголд иржээ.



Фотог Э.Зоригт

► **-Таны өмнө нь ажиллаж, амьдарч байсан орнуудтай харьцуулахад Монголд ямар ялгаа байна вэ?**

-Дөнгөж ирээд хоёр хонож байтал туслах маань орж ирээд “Та яг одоо Байгаль орчны сайдтай уулзах шаардлагатай, одоо явахгүй бол оройтно” гэдэг байгаа. Өмнө нь бүх ажлаа эхлээд сайтар төлөвлөөд, дараа нь амжуулдаг байсан хүний хувьд “яг одоо” гэсэн үг маш их гайхашрал төрүүлж билээ. Харин одоо энэ үгэнд дасжээ (ингэж хэлээд хатагтай Мюллер инээв). Гэхдээ би эх орондоо буцаж очоод энэ үгийг хамаагүй хэрэглэхгүй юмсан гэж өөртөө сануулдаг. Учир нь энэ зарчим Германд хэрэгжихгүй. Улс орон бүрийн хувьд заавал тодорхой хугацаа өнгөрсний дараа ойлгодог соёлын болоод нийгмийн ялгаа байдаг. Өнөөдөр Монгол улсын хөгжил ахархан хугацаанд асар хурдацтай өрнөж байна. Энэ нь мэдээж нийгэмдээ эргээд үр нөлөө үзүүлнэ. Нэг талаасаа хувь хүн, компани, улс оронд томоохон боломж бүрдэж буй ч Монгол шиг залуу ардчилсан тогтолцоотой оронд асуудалтай. Хурдацтай өөрчлөлт явагдахыг би Хятад улсын жишээн дээр харсан. Гэхдээ мэдээж тэндхийн улс төрийн тогтолцоо Монголынхоос ихээхэн ялгаатай. Бусад улстай харьцуулах өөр том ялгаа юу вэ гэвэл Герман-Монголын харилцааны асуудал. Германд сурч, ажиллаж байсан герман хэлтэй монголчуудын томоохон сүлжээ байдаг. Гадаад орны иргэн хэн бүхнийг энэ сүлжээнд тавтай морилохыг урьдаг. Монголд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхөдтэй байгаа нь миний зүгээс алба, амин хувийн ажлаа явуулахад ихээхэн дөхөм болдог. Энэ тухайд маш сэтгэл хангалуун байдгаа хэлье. Монголд ирэхийнхээ өмнө танай өвлийг яаж давна даа гэж санаа зовж байсан. Харин, одоо гурав дахь өвлөө Монголд өнгөрүүлж буй хүний хувьд миний бодож байсан шиг хатуу ширүүн биш, харин ч тааламжтай санагдаж байна. Нартай, хуурай өвлийн улирал Германы арваннэгдүгээр сараас хавьгүй дээр санагддаг.

-Та Хятад улсад ажиллаж байх

үедээ 2000, бас 2002 онд хоёр ч удаа Монголд ирж амралтаа өнгөрүүлсэн тухай дурдсан. Хэдэн жилийн дараа Монголд ирэхэд хамгийн түрүүнд анзаарагдсан өөрчлөлт юу байсан бэ?

-Урьд нь нийслэлд харж байсан бүхнийг таниагүй. Амралтын үеэр амьдарч байсан байшин хаана байж болохыг мэдэхээ больсон байсан. Учир нь олон тооны шинэ барилга сүндэрлэж, бүх юм өөрчлөгдсөн байсан. Түүнчлэн хөдөөнөөс хот руу шилжин суурьших байдал газар авч, уул толгод, хотын зах руу ч орон сууцны шинэ хорооллууд боссон байсан. Өмнө нь тийм байгаагүй. Монгол улсын хөгжил мэдэгдэхүйц хурдтай өрнөж буй. Энэ хөгжил нь улс орондоо ашиг тусаа өгнө гэдэгт найдаж байна.

-Нийслэлд амьдрал сайжирсан уу?

-Агаарын бохирдлыг харваас үгүй гэж бодож байна. Монгол эрчим хүч, дулаан хангамжийн хувьд нэлээд асуудалтай байдгийг манайхаас хэрэгжүүлдэг эрчим хүчний үр ашгийн төслөөс мэдэрдэг.

-Сүүлийн үед Герман- Монголын хамтын ажиллагаа, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагаа ихээхэн өргөжиж байна. Үүнтэй холбоотойгоор ГОУХАН-ийн зүгээс ямар үйл ажиллагаа явуулж байна вэ?

-Юуны өмнө Монголд үйл ажиллагаа явуулж буй “Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг” (GIZ)-ийн талаар товч дурдахыг хүсч байна. Урьд нь тус байгууллага GTZ буюу “Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг” гэсэн нэртэй байсан. Бид Монголд 20 гаруй жил үйл ажиллагаа явуулж байна. Манайх Германы Холбооны Засгийн газрын хэрэгжүүлэгч хөгжлийн байгууллага. Байгууллагын нэг жилийн төсөв ойролцоогоор арав орчим сая евро. Өнөөдөр бид гурван үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр нь, био-тархалт, эрчим хүчний үр ашигтай зарцуулалт, эрдэс баялгийн менежмент зэрэг болно. Түүнчлэн техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын чиглэлийг мөн

хамардаг. ГОУХАН нь DED, InWent байгууллагуудтай нэгдсэнээр зарим өөрчлөлт гарсан. Байгууллага юуны өмнө ажиллах хүчний хувьд өргөжсөн. Одоо манайх 100 гаруй ажилтантай. Сонирхолтой нь манайх Монголд үйл ажиллагаа явуулж буй Германы хамгийн том ажил олгогч байгууллага юм.

-Ямар асуудалд түлхүү анхаарч ажиллаж байгаа вэ?

-Техникийн мэдлэг, туршлагыг нэвтрүүлэх тал дээр илүү анхаарах болсон. Манай мэргэжилтнүүд бүх түвшний компани, байгууллагатай ажиллах найман төрлийн арга хэрэгсэлтэй. Үүнийг бид “Манай борлуулалтын өвөрмөц шинж чанар” гэж нэрлэж буй. Монгол оронд техникийн дэмжлэг тусалцаа асар их эрэлттэй байгаа. Энэ салбарт бид Оюутолгой төсөл болон Мянганы сорилтын сантай хамтран ажиллаж байна. Жишээлбэл, өнгөрсөн жил дээрх байгууллагууд мэргэжлийн сургууль болон коллежийг тоног төхөөрөмжөөр хангасан билээ. Бидний хувьд тэрхүү тоног, төхөөрөмж дээр ажиллах мэргэжилтнүүдийг авчирч, туршлага болон заах аргаар дэмжинэ. Монголын талаас үүнийг маш талархалтайгаар хүлээж авч байгаа.

-Монгол улсад техникийн тусалцаа үзүүлэх, ноу-хау нэвтрүүлэх аль аль нь маш чухал гэж бодож байна.

-Эрэлт хэрэгцээ бидний хийж чадах хэр хэмжээнээс хавьгүй илүү байгаа нь анзаарагддаг. Иймээс бид өөр газруудад манай арга техникийг нэвтрүүлэх талаар бусад байгууллагатай хэлэлцэж байгаа. Аливаа улсын хөгжилд боловсрол, мэргэжлийн сургалт чухал үүрэг гүйцэтгэдэг.

-Өдгөө бидэнд илүү шинэлэг өрсөлдөх чадвартай байх шаардлага тулгамдаж буй. Та энэ талаар юу хэлэх вэ?

-Тиймээ. Энэ нь “Герман-Монголын бизнесийн өдрүүд”-ийг зохион байгуулах болсон нэг шалтгаан юм. Хувийн хэвшилтэй эрчимтэй хамтарч буй нь бидний ажлыг илүү тогтвортой бөгөөд үр дүнтэй болгоно гэдэгт бид итгэдэг. ►



шаардлагад нийцсэн мэдлэг, чадвартай шилдэг ажиллах хүч олох тийм ч амар биш. Манай байгууллагад маш сайн, чадавхтай ажиллах хүчин хэрэгцээтэй байдаг. Үр дүнтэй ажиллахын тулд бидэнд ажлын сайн нөхцөл зайлшгүй шаардлагатай. Ажиллагсадын дунд “дулаан уур амьсгал” бүрэлдүүлэх чадварт ихээхэн ач холбогдол өгөх ёстой. Эдгээр нь бусадтай харилцах, нэгдмэл байх, хөтлөх ур чадвартай байх зэрэг юм. Сүүлийн хоёр жил манай байгууллагаас хоёрхон хүн л саналаараа өөр компанид орсон. Хамтран ажиллагч байгууллагуудаа өөр хооронд нь холбож өгөх нь хамтын ажиллагааг хөгжүүлэхэд маш чухал. Миний үзэж байгаагаар тогтвортой удирдлагатай байхын тулд хүний нөөцийн менежментдээ маш их анхаарал тавих нь чухал.

-Зөвхөн эдийн засгийн түвшинд биш, хамтын ажиллагааны бүх л салбарын тухайд Герман-Монголын хамтын ажиллагааны ирээдүйг Та хэрхэн төсөөлж байна вэ?

-Герман-Монголын хамтын ажиллагааны тухайд би сэтгэл зовохгүй байна. Учир нь бидний хамтын ажиллагаа маш хүчтэй, урт хугацааны уламжлалтай. Германд суралцаж буй монгол оюутны тоо орчин үед буурсан гэж зарим нь хэлдэг. Минийхээр энэ бол хэвийн үзэгдэл. Өнөөдөр гадаадад сурах хүсэлтэй оюутнуудад маш өргөн боломжууд байна. Германд суралцаж төгсөөд эх орондоо ажиллаж, амьдрахаар эргэн ирсэн олон хүн байдагт би баярладаг. Улс орны тэргүүнүүдийн албан ёсны харилцан айлчлалууд ч мөн манай хоёр орны хамтын ажиллагааны эзлэх байр суурийг харуулж байна. Германы их сургуулиудын оролцоотойгоор археологийн олдвор малтах ажлыг мөн хамтран хийдэг. Монголд өрнөж буй эрчимтэй хөгжил, томоохон өөрчлөлтүүдтэй холбоотойгоор хоёр орны хамтын ажиллагааны хэлбэр өөрчлөгдөх нь дамжиггүй. Адил тэнцүү эрхтэй түншүүд болохын хувьд алсын хараа, зорилго, үүргийнхээ тухай байнга хэлэлцэж байх шаардлагатай. Миний зүгээс энэхүү хэлэлцүүлэгт удахгүй оролцохыг хүлээж байна. ■

▶ Хамтын ажиллагаагаа хөгжүүлэх олон боломж бий. Манай байгууллага хамтран ажиллахын зэрэгцээ зарим тусгай үйл ажиллагаа, төслийг санхүүжүүлдэг. Энэ нь ГОУХАН-ийн бизнесийн баримжаатай хэсэг бөгөөд Монголын хувьд тэгтлээ сайн танигдаагүй юм. “Эрдэс баялаг, түүхийн эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөрөөс санаачилсан “Герман-Монголын бизнесийн өдрүүд” арга хэмжээ нь том амжилт болсон. Оролцогчдын тоо ойролцоогоор 1000 хүрч, энэ тоо гурван өдрийн турш буураагүй, харин ч нэмэгдэж байсан. Бизнес, шинжлэх ухаан, төрийн бус байгууллагын гээд өргөн хэмжээний төлөөлөл оролцсон билээ. Уг арга хэмжээ нь Монголын болон Европын бизнесийн хүрээнийхэн орчин үеийн корпорацийн менежментийн талаар санал бодлоо чөлөөтэй солилцох индэр болох зорилготой байв.

Арга хэмжээнд “Siemens”, “Thyssen Krupp”, “Bilfinger Berger”, “Audi”, “Linde” гээд Германы нэрд гарсан пүүс, компаниудаас гадна “Номин холдинг” гэх мэт Монголын томоохон компаниудын төлөөлөл оролцсон. Уг арга хэмжээ нь хоёр орны бизнесийн салбарынхны харилцан суралцах талбар болж чадлаа. Энэ нь Герман-Монголын худалдааг өргөжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

-Таны бодлоор төслийн сайн менежмент гэж юуг хэлэх вэ. Монгол улсад олон төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна. Тэгвэл аливаа төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд менежерүүд чухам юуг анхаарвал зохих вэ?

-Миний ойлгож байгаагаар менежментийн хамгийн чухал асуудлын нэг нь яах аргагүй хүний нөөцийн менежмент. Төслийнхөө

ХЭРЭГЦЭЭ

АГУУЛАХЫН БИЗНЕС ЭХЛҮҮЛЭГЧДЭД ӨГӨХ САНАА

Х.БӨРТЭ

...Монголын зах зээл бараа, бүтээгдэхүүнийг дамжуулах нь байтугай холимог хэлбэрийн агуулахын үйл ажиллагаа ч дорвитой хөгжих хэмжээнд хүрээгүй байна. Тиймээс гаднын орнуудад хоцрогдсон ч манайд эхэлж буй хадгалан дамжуулах агуулахын салбарыг хөгжүүлж, улсын чанартай болгох хэрэгтэй...

Монгол хүнсний ногоо, улаан буудайгаа хадгалах зорь, агуулахгүй сандарч байхад Герман тэргүүтэй зарим улсад бараа, бүтээгдэхүүнийг хадгалах биш, зөвхөн дамжин өнгөрүүлэх агуулах, зоорийг нанотехнологийн аргаар шинэчлэх тухай ярьж байна. Энэ бол Монголын хувьд шинэ салбар. Учир нь манайд агаарын тээврийн болон төмөр замын салбарт энэ төрлийн хөгжил битгий хэл эхлэл нь ч тавигдаагүй байна. Харин худалдааны салбарт сүүлийн жилүүдэд ганц нэг агуулах баригдаж, ашиглалтад орж байгаа билээ.

Өнгөрсөн сарын 22-24-нд болж өнгөрсөн Герман-Монголын бизнесийн өдрүүд арга хэмжээний үеэр “Агуулахын менежментийн стратеги”, “Агуулахын зохион байгуулалт ба технологийн шийдэл”, “Агуулах дахь нөөцийн менежмент” гэсэн сонирхолтой илтгэлүүдийг хэлэлцүүлсэн юм. Тэндээс монголчуудад санаа авах, цаашлаад хуулбарлаж, Монголын хөрсөнд буулгаад авах цөөнгүй сайхан санаа байсан ч манай энэ төрлийн үйлчилгээ эхлүүлэгчдээс уг хурлыг сонирхогч цөөн байв.

Богино хугацаатай байх тусам ашиг өснө

Ноён профессор Клаус Шпихерийн хэлэлцүүлсэн “Агуулахын менежментийн стратеги-Хэрэгцээндээ зохицсон стратегийг хэрхэн сонгох вэ” сэдэвт хэлэлцүүлгээс бидэнд авах хийгээд, туршиж, хэрэгжүүлж болох олон санаа байсан. Дэлхийн олон оронд ялангуяа өндөр хөгжилтэй Европын орнуудад агуулах, дамжин өнгөрүүлэх агуулах нь ширүүн өрсөлдөөнтэй бизнес болж хөгжсөн бөгөөд энэ тоглоомоор тоглосон бизнесмэн төдийлэн алдагдал хүлээдэггүйг илтгэлийнхээ эхэнд Шпихер дурдаж байсан.

Агуулахын төрлийн хувьд ачаа, бараа хадгалдаг хийгээд, зөвхөн дамжин өнгөрүүлэх зориулалттай, мөн холимог гэж ангилдаг байна. Хадгалах зориулалттай агуулахыг ашиг, орлоготой байлгахын тулд үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулах, эсвэл хадгалах хугацааг ангилалтайгаар тогтоох нь чухал юм. Тухайн барааг нэг үнээр олон хоног

хадгалснаас богино хугацаагаар өөр өөр үнээр хадгалах нь бизнес эрхлэгчид ашигтайг илтгэгчид онцолж байсан. Харин дамжин өнгөрүүлэх зориулалттай агуулахыг бараа, тээшийг ачих, авахад хамгийн хялбар, цэгцтэй байлгах зохион байгуулалт хийгээд агуулахын хэрэгслүүд бат бөх байхыг илүүд үзэх нь тухайн бизнесмэнд ашигтай аж. Учир нь байнга хөдөлгөөнд орших уг тасгийн тасалгаа, зөөх тэрэг болон бусад техник амархан эвдэрдэгийг туршлагаасаа өгүүлсэн юм. Сүүлийн таван жилд Европын орнуудад дамжин өнгөрүүлэх агуулахын үйлчилгээ маш хурдацтай хөгжиж, ихэнх жуулчин, аялагч энэ салбараар үйлчлүүлэхийг илүүд үздэг болсон байна. Холимог агуулахын хувьд хадгалах хийгээд дамжих тээш, ачааг тусад нь байрлуулах тасалгаа байх нь ойлгомжтой. Агуулахын төрөл ямар байх нь үйлчлүүлэгчид нэг их чухал бус харин бага талбайд, цэгцтэй зохион байгуулсан шийдэл л таатай сэтгэгдэл үлдээдэг байна. Мэдээж найдвартай, түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээгээр үйлчлүүлэгчийн итгэлийг хүлээнэ.

Агуулахын имижийг ингэж бүрдүүл

Үйлчлүүлэгчийг онгоц эсвэл галт тэрэг өөр юу байдаг юм тээврийн хэрэгслээсээ буухад нь түүний тээш, чухал бараа гарт нь ирж байх нь хамгийн чухал. Үүний тулд маш эмх цэгцтэй, зохион байгуулалттай, түргэн ▶

Монгол улсын гаалиар нэвтэрсэн бараа эргэлтийн тоон мэдээ

	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Нийт бараа эргэлт	1150.3	1159.2	1214.7	1416.9	1890.8	2249.2	3028.4	4119.3	5779	4023.1	6108.6	11415.8
Импорт	614.5	637.7	690.7	801	1021.1	1184.3	1485.6	2170.1	3244.5	2137.7	3200.1	6598.4
Экспорт	535.8	521.5	524	615.9	869.7	1064.9	1542.8	1949.2	2534.5	1885.4	2908.5	4817.5

Эх сурвалж: ГЕГ

► шуурхай ажиллагаа шаардлагатай. Ингэж ажиллахын тулд агуулахын дотоод зохион байгуулалт, дэг журмыг сайтар хангах ёстой. Үүнд нөлөөлөх хамгийн чухал зүйл нь агуулахын барилгын зохион байгуулалт, дизайн гэдгийг илтгэгч доктор Шпихер онцолсон. Агуулахын үйлчилгээ хөгжсөн ихэнх оронд агуулахын байр олон давхар байдаггүй аж. Азийн цөөн оронд тухайлбал, БНХАУ-ын ихэнх агуулах олон давхар байдаг байна. Энэ нь бизнесийн салбарт зохимжгүй, эрсдэлтэй бөгөөд үр ашиггүй имижид тооцогддог байна. Учир нь олон давхар байх тусам ачаа, тээшийг дээш доош нь зөөх илүү техник, хүч хөдөлмөр, цаашлаад цахилгаан, мөнгө урсаж байдаг аж. Харин цөөн давхартай, зөв, цэгцтэй зохион байгуулалттай агуулахад багтахгүй зүйл гэж үгүй гэсэн юм. Энэ нь хөдөлмөр хийгээд ашиггүй зардлыг хэмнэдэг байна. Мөн мэдээллийн сан, бараа материалын бүртгэлийн тасагт асар их хариуцлага ногдож байдаг тул энэ тасгийг өргөжүүлэх

тал дээр үргэлж анхаарах нь ашигтай ажиллахын нэг нууц гэсэн. Өөрөөр хэлбэл сайн бүртгэгч, зөв зохион байгуулалт, цэгцтэй хадгалалт, аюулгүй байдал, шуурхай ажил, түгээлт нь энэ салбарын шилдэг имиж юм. Үүнээс гадна амархан муудаж, гэмтдэг бараа, материал, хүнсний бүтээгдэхүүнд тохирох тасалгаа, агуулахыг бий болгох нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжыг нэмнэ.

Гол үйлчлүүлэгч нь худалдааны салбар

Өдгөө дэлхий дээр олон улсын чанартай 800 гаруй агуулах үйл ажиллагаа явуулж байна. Гэхдээ тэдний ихэнх нь худалдаа, бизнесийн салбарынхны ачаа, бараа, тээшийг хадгалж, эздэд нь хүргэж өгч байна. Энэ нь өдрөөс өдөрт ажлаа хялбарчлахыг эрмэлзэж буй агуулахын үйлчилгээ бүрэн төгс боловсроогүй гэдгийг илтгэнэ хэмээн “Агуулахын зохион байгуулалт ба

техникийн шийдэл” сэдэвт илтгэл тавьсан Инго Шрайбэр хэлсэн юм. Агуулахын үйлчилгээний дэлхийн шилдэг гэгдэх бизнесмэнүүд зөвхөн дамжин өнгөрүүлэх салбарыг жишиг болгохоор хөгжүүлэхийг зорьж байгаа ч тийм ч бүтэлтэй биш байгааг Шрайбэр онцолсон. Учир нь дэлхий дамнасан худалдаа, наймаа хийгээд ачаа барааны эргэлт холимог, эсвэл хадгалалтын системийг илүүтэй сонгож байгаа нь дамжиггүй. Манай улсын хувьд “Номин холдинг” зэрэг томоохон худалдааны компаниуд өөрсдийн бараа, бүтээгдэхүүнийг хадгалах агуулах байгууламжуудыг барьж эхэлж буй. Улсын хэмжээнд 2011 оны байдлаар гаалийн баталгаат агуулах 35, хяналтын талбай 100, түр агуулах 21, гаалийн баталгаат нэг үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгааг Гаалийн ерөнхий газрын худалдаа, борлуулалт хариуцсан мэргэжилтэн Г.Цолмон хэлж байсан.

Мөн дамжин өнгөрөх агуулахын үйлчилгээ эрхэлдэг цөөн тооны төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж эхэлж байгааг дурдсан. Тухайлбал, “Эрин интернэшнл” компани Монголын нутгаар шууд дамжин өнгөрөх тээвэрлэлтийн ачаа барааг өөрийн тусгай бүсэд тодорхой хугацаагаар хүлээн авч, холбогдох үйлчилгээг үзүүлэх, Монголын нутгаар дамжуулан реэкспорт хийж буй тээвэрлэлтэд өөрийн агуулах, талбайг ашиглах замаар тодорхой нөхцөлийг нь бүрдүүлэн тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлж байгаа аж. Энэ мэтээр эхэлж байгаа нь сайн. Харин одоо бидэнд менежмент хэрэгтэй. Монголын зах зээл бараа, бүтээгдэхүүнийг дамжуулах нь байтугай холимог хэлбэрийн агуулахын үйл ажиллагаа ч дорвитой хөгжих хэмжээнд хүрээгүй байна. Тиймээс гаднын орнуудад хоцрогдсон ч манайд эхэлж буй хадгалан дамжуулах агуулахын салбарыг хөгжүүлж, улсын чанартай болгох хэрэгтэй юм. Уул уурхай дагасан бизнес, дэлхийг хэрсэн худалдааны салбарууд манайхыг онилж буй энэ цаг үед агуулахын бизнес улсын төсөв хийгээд бүтээн байгуулалтад ашигтай бус уу. ■



“Номин холдинг” компанийн агуулах

ХАНГАМЖИЙН СҮЛЖЭЭ

ЛОГИСТИК, КЛАСТЕР, ИННОВАЦИ...

Б.УУГАНБАЯР

..Герхард Вакенхүүт илтгэлдээ “Товчхоноор хэлбэл, аливаа бараа, бүтээгдэхүүнийг А цэгээс Б цэгт хүргэх бүх үйл явцыг хангамжийн сүлжээ гэж үзэж болно. Үүнд худалдан авалт-нөөцлөлт, хадгалалт- түгээлт, нийлүүлэлт багтаж буй юм” гэв...

Ханган нийлүүлэлтийн сүлжээ. Энэ үг эдийн засгийн огцом өсөлтөөрөө дэлхийд гайхуулж буй Монгол улсын өргөжин тэлж буй зах зээлд хүч түрэн орж ирж байгааг “Герман-Монголын бизнесийн өдрүүд” чуулга уулзалт “зарлан тунхаглалаа”. Эл өдрүүдэд ХБНГУ-ын салбар салбарын бизнесмэн, эрдэмтэн, судлаачид мэдээлэл хийж, туршлагаа хуваалцсан. Харин “Хангамжийн сүлжээний менежмент өсөж буй зах зээлд хэрхэн үйлчилгээ үзүүлэх вэ” сэдэвтэй хоёр дахь өдрийн хурлын үеэр Клаус Шпихер “Хангамжийн сүлжээний технологи-олон улсын болон дотоодын бизнес дэх хангамжийн сүлжээний ач холбогдол” гэсэн сонирхолтой илтгэл тавьсан юм. Фрауенхофийн материал, логистикийн хүрээлэнгийн профессор түүний илтгэлийг манайх дараагийн дугаартаа бүрэн эхээр нь нийтлэх болно. Түүний ярьснаас үзэхэд Монголын хурдацтай хөгжилд тулгамдсан асуудал болоод буй хангамжийн сүлжээний менежмент болон логистикийн салбарт санаа авч хэрэгжүүлэх олон зүйл байсан гэдгийг тэмдэглэе.

“Номин холдинг”-ийн Автомат нисэх хүчний материал-техник хангамжийн хэлтсийн гүйцэтгэх захирал Герхард Вакенхүүт илтгэлдээ “Товчхоноор хэлбэл, аливаа бараа, бүтээгдэхүүнийг А цэгээс Б цэгт хүргэх бүх үйл явцыг хангамжийн сүлжээ гэж үзэж болно. Үүнд худалдан авалт-нөөцлөлт, хадгалалт-түгээлт, нийлүүлэлт багтаж буй юм” гэв.

Уул уурхайн хөгжил, эдийн өсөлттэй холбоотойгоор Монголд олон улсын томоохон компани, корпорациуд, өндөр боловсрол, мэдлэг, мэдээлэлтэй хэрэглэгчид зэрэг шинэ төрлийн худалдан авагч, үйлчлүүлэгчдийн эгнээ өргөжиж буй нь хангамж, нийлүүлэлтийн шинэ эрин айлчилсныг илтгэх. Энэ нь Барууны орнуудад урт хугацаанд бий болгосон хангамжийн сүлжээний менежментийг Монгол улс богино хугацаанд байгуулах шаардлага үүсгэж байна. Гаднын туршлагаас харахад худалдан авалт-нөөцлөлт, хадгалалт- түгээлт, нийлүүлэлт гурвыг аль болох зардал багатай, шат дамжлага цөөхөн, үр ашигтай зохион байгуулахад хаана хаанаа анхаарал

хандуулж, чухлаар авч үзэж байдаг аж. Түүнээс биш, манайх шиг тариа, ногоо ахиу хураасан жилээ нөөцлөх агуулах савгүй сандарч, ургац алдсан жилээ улаан буудайн эрэлд мордож амьдрах биш юм.

Сүүлийн үед монгол хэлний үгийн санд логистик, кластер, инноваци гэх мэт үгс нэвтэрч, эрчимтэй хөгжиж буй. Хөгжлийн ритмд бизнес, эдийн засгийг үр ашигтай, ухаантай хөтөлж явуулах эдгээр “зэмсэг”-ийн ая данг монголчууд хэрхэн эгшиглүүлэх вэ гэдэг гадаад, дотоодын мэргэжилтэн, судлаачдын сонирхол татсан асуудал юм. Нөгөө талаараа шинэ тутам хөгжүүлж байгаа салбаруудад бусдын туршлагаас суралцаж, богино хугацаанд амжилттай хөгжүүлэх боломж бололцоо бидэнд бий. Ялангуяа Монгол улсын хувьд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд оруулах нь чухал гэдгийг ноён Шпихер илтгэлдээ онцолж байсан. Жишээ нь, Германд гэхэд загасны аж ахуй эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг төр худалдаж авдаг байна. Мэдээж хэчнээн мянган тонныг нөөцөлмөөр байна хүссэн хэмжээгээрээ авч хадгалах, зориулалтын хөргүүртэй. Төр нөөцөлсөн загасаа борлуулахын тулд дуудлага худалдаа зохион байгуулна. Дуудлага худалдаанд хүсвэл даатгалын компани ч оролцох эрхтэй гэсэн. Үүнийг сайн зохион байгуулалттай хийж чадах аваас ▶



Шог зургийг А.Амарсайхан

► үндэсний үйлдвэрлэгчдэд дэмжлэг болно гэсэн үг.

Мөн Шпихер “Хангамжийн сүлжээний Мастер төлөвлөгөө”-тэй болох хэрэгтэйг ч монголчуудад зөвлөсөн. Түүнчлэн хангамжийн сүлжээг оновчтой бий болгоход логистикийн асуудлыг орхигдуулж болохгүй аж. Логистикийн салбарыг Герман улс сонгодог утгаар нь хөгжүүлж чаджээ. Тус улсын эдийн засгийн хөдөлгөгч хүч нь логистик гэсэн. Тэгвэл логистик нь инновацийн хөдөлгүүр болдог тухай Шпихер хэлсэн. Логистикийн гүйцэтгэлийн индатораар Монгол улс 141 дүгээрт “гэлдэрч” яваа бол Герман улс нэгд жагсдаг. Харин манай урд, хойд хөрш, АНУ зэрэг орон энэ салбарт тийм ч ололттой биш гэнэ. Герман, Швед, Сингапур гэх мэтийн орон илүү сайн хөгжүүлсэн байдаг аж. Германд ДНБ-ий долоон хувийг логистикийн салбар эзэлдэг бөгөөд манай улсын хүн амын гуравны хоёртой тэнцэх хэмжээний хүн энэ салбарт ажилладаг. Логистикийг хөгжүүлэхэд хатуу дэд бүтэц байх хэрэгтэйгээс гадна хүний нөөц чухал. Хэрвээ хөгжүүлж чадах юм бол шинэ зах зээл нээгдэж, хөрөнгө оруулагч, жуулчдыг ядах юмгүй “уургалж”, хөршүүдтэйгээ ч хамтарч ажиллахад хялбархан болдог байна. Мэдээж ард

иргэдийн амьдрал сайжирна.

Хангамжийн нийлүүлэлтийн сүлжээг их хотын ачаалал, энхэл донхool ихтэй зам, алслагдсан зэлүүд хөдөө, орон нутагтай Монголд үр дүнтэй хэрэгжүүлэх амаргүй ч ухрах эрх бидэнд байхгүй. Тухайлбал, Замын-Үүдээс Улаанбаатар хүртэл 250 км л хатуу хучилттай зам бий. Үлдсэн цэлийсэн урт шороон замаар “тонгочуулан” байж тээвэрлэж ирж буй барааны тээврийн зардал өндөр гарахаас аргагүй. Тэр хэрээр машин техникийн эвдрэл гэмтэл их гарч, жолоочийн эрүүл мэндэд ч халгаатай. Энэ мэтийн шалтаг шалтгаан нь барааны үнийг хямд байлгах үндэсгүй болгодог байна. Эвдэрсэн машинаа засах, алжааж ядарсан жолоочийн эрүүл мэндэд компаниас зарцуулсан мөнгө эцсийн мөчид хэрэглэгчийн халааснаас “урсах” нь харамсалтай. Гэтэл дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлт толийсон замаар хийгддэг учраас шуурхай чанар, хямд үнийг хадгалдаг байна. Манайд логистикийн асуудал зөвхөн автозамаар тогтохгүй төмөр замын тээвэртэй холбоотой вагон цөөхөн, баталгаат агуулахууд болоод тээвэр, зуучийн компаниудад ачаа ачиж-буулгах кран хүрэлцээгүй гээд түмэн зовлон бий. Тэгвэл

энэ байдлыг Германд маш нарийн зохицуулсан байдаг аж. Тус улсын хувьд тээврийн зардалд шатахуун, жолоочийн хөлс хоёр л ахиу жин дардаг байна. Бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн системийг тусгайлан хуульчилсан байдаг гэнэ. Ингэхдээ логистикийн компаниуд ачаа бараа тээвэрлэх горим, жолоочийн ажиллах цагийн хуваарь, үүрэг хариуцлага маш нарийн заалттай. Тээврийн компанийн жолооч нар өдөр хэдэн цаг ажиллах ёстой, тухайн бараа бүтээгдэхүүнийг хэдэн цагт хаана хүргэсэн байх ёстойг хаана хаанаа ягштал мөрддөг. Зам, тээврийн хяналтын газар болон Замын цагдаагийн газар хамтарч энэ тал дээр хяналттай ажиллах жишээтэй. Мөн тээвэр, логистикийн компаниуд ч үүргээ ухамсарлаж, жолооч нар нь дээд зэргийн хариуцлага, ёс зүйтэй. Тийм болохоор жолооч нарт ямар ч барааг товлосон хугацаанаасаа нэг минут ч хоцроох эрх байдаггүй гэсэн үг. Түүнчлэн логистикийн олон компани байдаг учир ширүүн өрсөлдөөн үнийг харьцангуй доогуур түвшинд барьдаг гэх. Цаг ягштал баримталдаг, сахилга баттай Герман улсын хувьд логистикийн салбараа ийн хөгжүүлж чаджээ. Бидэнд тэднээс суралцаж зөв хөгжих том боломж байна. ■



ЛОГИСТИК

ХӨРСӨНДӨӨ ЗОРИУЛЖ ҮРЭЭ СУУЛГАХ ХЭРЭГТЭЙ

Э.ЗОРИГТ

“Герман-Монголын бизнесийн өдрүүд” чуулга уулзалтын үеэр DHL компанийн Азийн бүсийн төмөр зам болон далайн тээвэр, агаарын тээвэрлэлт хариуцсан дэд ерөнхийлөгч Bruno Selmoni-той логистикийн салбарын талаар ярилцлаа.

-Логистикийн талаар олон тодорхойлолт байдаг. Гэхдээ логистик нь зөвхөн тээвэр биш, төлөвлөлт, удирдлага ба хангамж, дэд бүтэц гээд олон асуудлыг хамарсан, өргөн хүрээтэй бие даасан салбар. Харин Та логистикийг юу гэж тайлбарлах вэ?

-Сайхан асуулт байна. Хэрвээ логистикийн талаар хамгийн богино тайлбар хэл гэвэл “Энэ бол хүмүүсийг аз жаргалтай болгодог үйл ажиллагаа” гэж хэлмээр байна. Мөн тухайн хүнийг өсөж хөгжихөөс эхлээд хүний амийг аврах хүртэл хамгийн ойрын туслагч гэж хэлж ч болох юм. Ер нь логистик нь маш өргөн цогц ойлголт учраас юу ч гэж тайлбарлаж болно.

-DHL компани бол логистикийн салбарт дэлхийд тэргүүлэгчдийн нэг. Тиймээс тус компанийн үйл ажиллагааны цар хүрээний талаар товч танилцуулахгүй юу?

-Өнөөдрийн байдлаар DHL компани нь 220 гаруй оронд

үйл ажиллагаа явуулж байна. Энэ том сүлжээний нэг хэсэг нь Монгол улс юм. Манай компани дэлхийд ойролцоогоор 3000 гаруй үйлчилгээний төвтэй, 275 мянга орчим ажилтантай. Товчхондоо DHL нь дэлхийг хэрсэн логистикийн томоохон компани гэж хэлж болно.

-Монголд логистикийн салбарын хөгжил сул байгаа. Та энэ салбарт туршлагатай хүний хувьд бидэнд ямар зөвлөгөө өгөх вэ?

-Би Монголд ирээд удаагүй байна. Тиймээс танай улсын эдийн засаг, улс төр болон бусад зүйлийн талаар тийм ч сайн мэдэхгүй. Тиймээс танай логистикийн салбарт ийм зүйл хийх хэрэгтэй, энэ болохгүй гэж хэлж чадахгүй. Гэхдээ логистик гэдэг бол тухайн улсын хөгжлийн түлхүүр юм. Түүнчлэн эдийн засгийн тулах баганын нэг. Тэр утгаараа логистикийн салбарын үйл ажиллагааг хөгжүүлэхийн тулд гурван хүчин зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд, Засгийн газар,

тээвэр зуучийн компани, тээвэрлэгч гурав юм. Энэ гурван хүчин зүйл нэг баг болж хамтран ажиллаж чадвал логистикийн салбар хөгжиж чадна. Үүнээс гадна дэд бүтцийн хөгжил чухал. Монгол улсыг логистикийн салбарт юм хийгээгүй гэж би хувьдаа хэлж чадахгүй. Герман Монголын бизнесийн өдрүүдийн хуралдааны үеэр монголчуудын тавьж байгаа илтгэлээс харахад, бүгд логистик гэж юу вэ гэдгээ мэддэг. Хөгжүүлэх арга замыг нь бас олж харсан. Тэрбүү хэл, хөрөнгө оруулалт хийгээд эхэлсэн байна. Түүний нэг жишээ нь төмөр зам барихаар төлөвлөж байгаа явдал юм. Түүнчлэн авто замын сүлжээ, шинээр баригдах нисэх онгоцны буудал гэх мэт. Эдгээр нь логистикийг хөгжүүлэх гол гүүр.

-Та хэлж байна л даа гурван гол хүчин зүйл байдаг талаар. Тэгвэл өнөөдөр тус салбарыг хөгжүүлэхийн тулд Засгийн газрын үүрэг оролцоо хэр байх ёстой юм бол.

-Гааль, Мэргэжлийн хяналтын ▶

▶ газар гэдэг ч юм уу, төрийн оролцоо бүхий хяналт, шалгалт явуулдаг газарт хүнд суртал их байдаг. Энэ нь логистикийн салбарын хөгжлийг хойш чангаадаг. Хэдийгээр хянаж шалгах нь зөв ч аль болох хүнд сурталгүй, цогц үйлчилгээ үзүүлдэг болох нь аль аль талдаа хэрэгтэй байдаг. Тиймээс Засгийн газар энэ тал дээр анхаарч, нэг цэгийн үйлчилгээг хүрэлцээтэй хэмжээнд бий болгох, хүнд сурталыг халах хэрэгтэй. Өнөөдөр аливаа бизнест амжилттай үйл ажиллагаа явуулахын тулд аль болох шуурхай байх нийгмийн шаардлага байна. Цаг бол алт учраас минут, секунд бүхэн ашиг хийгээд алдагдал байдаг. Тиймээс бид цаг хугацааны зарцуулалтын тухайд зайлшгүй анхаарах хэрэгтэй. Тухайлбал, бичиг цаасны ажлаа цахим хэлбэрт шилжүүлж болно. Түүнээс биш, гаалийн бичиг баримтыг заавал гааль дээр очиж авна гээд байвал цаг хугацаа их алдах юм. МҮХАҮТ-аас гаргасан судалгаанд дурдсанаар бичиг баримт бүрдүүлэх асуудал их цаг авдаг, хүнд суртал дагуулдаг гэдэг нь харагдсан.

-МҮХАҮТ-аас “Монгол улсад бизнес хийх замын зураглал” судалгаанд дурдсанаар манайд импорт юм уу, экспорт хийхийн тулд 70 гаруй хоног зарцуулж 10 гаруй бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай гэсэн байна билээ. Гэхдээ шинэчлэлийн Засгийн газар бичиг баримтын тоог 3-4 болгох тал дээр ажиллаж байгаа. Харин гаднын орнуудад энэ асуудал хэрхэн зохицуулагдсан байдаг вэ?

-Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлж байгаа ихэнх орон энэ тал дээр аль болох уян хатан, бизнес эрхлэгчдийнхээ эрх ашгийг харгалзсан байдаг. Гэхдээ яг ийм тийм байдаг гээд шууд хэлэхэд хэцүү. Орон бүр өөрийнхөө эдийн засаг, улс төрийн байдлаасаа хамаараад өөр өөр шийдвэр гаргана шүү дээ. Харин миний баттай хэлж чадах нэг зүйл бол логистикийн үйл ажиллагаа явуулдаг ямар ч томоохон компани тухайн улсынхаа Засгийн газар, шийдвэр гаргах дээд байгууллагатай хамтарч, илүү ойрхон ажилладаг уламжлалтай. Энэ нь нэг талаар тус салбарын

21 МОНГОЛЫН ЭКСПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДЛАГАТАЙ ГАРЫН ҮСГИЙН ТОО ЗҮҮН АЗИ БОЛОН АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГТ ХАМГИЙН ӨНДӨР БАЙНА.

улс орны хөгжилд оруулдаг хувь нэмэртэй холбоотой бөгөөд нөгөө талаар талууд хамтран ажилласнаар нэг нь нөгөөгөө ойлголцож, харилцан туслалцах арга замаа олдогт оршино. Тиймээс л хамтран ажиллах чухал гээд байгаа юм.

-Манай улсын хувьд адил төстэй орны хөгжлийн загвараас эхлээд боловсролын салбарын арга аргачлалыг өөрийн орондоо нутагшуулахыг хичээдэг. Энэ талаар буруу зөв гэж төр, засгийн удирдлагууд их маргадаг. Энэ тал дээр Та юу хэлэх вэ?

-Аливаа зүйлийг бид дэлхийн хэмжээнд сэтгэх хэрэгтэй. Гэхдээ өөрийн болгож ашиглах учиртай. Түүнээс биш, дэлхийн хэмжээнд сэтгэж байна гээд энэ тэндхийн зүйлийг авч хэрэгжүүлэх гэх нь тийм ч таатай биш. Хамгийн гол нь өөрийн хөрсөндөө зориулж үрээ суулгах хэрэгтэй гэсэн үг. Өөрсдийн онцлог, давуу талаа юуны түрүүнд олж харж, түүнийгээ ашиглах хэрэгтэй. Ямар ч улс өөрийн онцлог давуу тал дээрээ л тулгуурлан хөгжлийн шинэ шатанд гардаг. Бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн хувьд ч гэсэн амжилтад хүрэхийн тулд давуу талаа ашигладаг шүү дээ.

-XXI зуунд техник технологийн салбарын хөгжил логистикийн хөгжлийг шинэ шатанд гаргасан гэж судлаачид үздэг. Өнөөдөр тус салбарт тулгамдаж байгаа асуудал юу байна вэ?

-Бид бол үйлчилгээ үзүүлдэг компани. Тэр утгаараа бид эдийн засаг болон хэрэглэгчдийн эрх ашиг дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг. Тиймээс эдийн засгийн өнөөдөр, маргааш, нөгөөдрийг тооцоолж, гарч болзошгүй эрсдэлд бэлэн байх зайлшгүй шаардлага гарч ирж байгаа юм. Өнөөдөр

логистикийн салбарт тулгамдаад байгаа асуудал бол яах аргагүй дэлхийн эдийн засгийн уналтын байдал юм. Дээрээс нь бидэнд нийгмийн хариуцлагаа ухамсарлах нь маш чухал. Өдгөө хэрэглэгчид бараа, бүтээгдэхүүний чанараас гадна тухайн компанийн үйл ажиллагааны ил тод байдал, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж байгаа эсэхэд ихээхэн анхаардаг болжээ.

-Уг нь энэ талаар эхлээд асуух ёстой байсан байх. Монголд ирээд төрсөн сэтгэгдэлээсээ бидэнтэй хуваалцахгүй юу?

-Би Швейцарь хүн. Монголын одоо байгаа цаг агаар нь миний төрсөн нутагтай их төстэй юм. Тийм ч хүйтэн биш, бас дулаахан гэж хэлж чадахгүй. Алтан шаргал навчис, зөөлөн үлээх салхи гээд л төрсөн нутгийг минь эрхгүй санагдуулна. Тэр ч утгаараа Монгол надад таалагдаж басхүү татагдаж байна. Дараа заавал тухтай ирнэ гэж бодож байгаа. Дээрээс нь танай орны хүн ардын хичээл зүтгэл их сайхан санагдлаа. Хүн бүр хийнэ, бүтээнэ гэх хүсэл эрмэлзлэлтэй байна.

-Манайд ирсэн зарим жуулчин Монголын үйлчилгээний салбарын чанарыг голдог. Харин та үйлчилгээний салбарыг удирдаж яваа хүн. Тэр утгаараа манай улсын энэ салбарын хөгжил ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ?

-Тухайн хүний юуг яаж хүлээж авахаас их зүйл шалтгаална. Миний хувьд үйлчилгээний салбарыг муу гэж хэлж чадахгүй. Зан харилцааны хувьд найрсаг, сэтгэлээсээ санагдсан.

-Ярилцлага өгсөн танд баярлалаа.

-Чамд болоод танай сэтгүүлийн хамт олонд ажлын өндөр амжилт хүсье. Дараа Монголд ирэхээрээ уулзахын ерөөл тавья. ■

ДЭЛХИЙН ЖИШИГ

СТАНДАРТЛАГ ДЭЛХИЙ

Э.ЗОРИГТ

...Сургалт, эмнэлгийн үйлчилгээ, хүнсний аюулгүй байдал, хот төлөвлөлт гээд бүх зүйл стандарттай. Тэр стандартад л нийцүүлж чадахгүй бол Европын холбоо хүлээж авахгүй “бака, чау” гэнэ...

тааруухан. Бараа бүтээгдэхүүн нь ч тодорхой стандартын дагуу үйлдвэрлэгдэх нь ховор.

Тэгвэл стандарт гэж юу вэ?

Стандарт гэх ойлголт нь бууны гол төмрийг нэг хэмжээтэй хийх дархан хүний бурхан ухаанаас эхтэй. Харин стандарт гэх ойлголт өнөөдрийг хүртэл хөгжих явцдаа нэг талаас бүтээгдэхүүн, үйлчилгээ өргөжин, олноор үйлдвэрлэх үе шат эхэлж, технологи цаашлаад чанарт нөлөөлөх асуудалд дэлхий нийт анхаарал хандуулах болжээ. Нөгөө талаас бөөнөөр үйлдвэрлэх, үйлчлэх үйл явц нь хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж эхэлсэн нь тухайн бүтээгдэхүүнийг аюулгүй гэдгийг зайлшгүй тодорхойлох нөхцөлийг бүрдүүлсэн аж. Иймд тодорхой шалгуур үзүүлэлтийг тогтоох, баримтжуулах, мөрдөх явдал хамгийн чухал болсон байна. Түүнчлэн ямар ч бизнесийг борлуулалтгүйгээр төсөөлөхийн аргагүй. Харин борлуулалтыг дэмждэг гол хүчин зүйл бол стандарт болон чанар юм. Монголын Стандартчилал хэмжил зүйн газрын тодорхойлсоноор “Стандарт бол эдийн засгийн болоод зах зээлийн харилцаанд чанд мөрддөг нэг ёсны хууль юм. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого, худалдан авах үйл явцад хэрэглэгчийн байр суурийг бизнес эрхлэгчидтэй харьцуулахад хүчгүй, сул дорой байдлыг тэнцүүлэх үүднээс тэднийг бизнес эрхлэхдээ баримтлах наад захын норм, хэм хэмжээ стандарт тогтоохыг шаарддаг. Энэ бол улс орон бүр бараа бүтээгдэхүүн ажил



Стандарт бол хүн төрөлхтний үйлдвэржилтийн гурван том хувьсгалын нэгд зүй ёсоор ордог. Бараа, бүтээгдэхүүнийг бөөнөөр үйлдвэрлэх боломж олгосон анхны алхам нь стандартжуулах явдал байсан гэдэг. Үүний дараа механикжуулах систем үйлдвэрлэлд нэвтэрсэн байна. Харин Хенри Фордын нэвтрүүлсэн угсрах шугам

гэж нэрлэдэг, орчин үеийн автомат үйлдвэрлэлийн суурь болох хөдөлмөрийн хуваарийн зарчим нь гуравдугаар том ололт болжээ. Энэ гурван зүйл нэгдсэнээр өдгөө бараа, бүтээгдэхүүнийг олноор нь үйлдвэрлэх, дэлхийн зах зээлд гаргах гээд олон давуу тал бий болжээ. Харин Монгол улсын хувьд стандартын талаарх мэдлэг

► үйлчилгээндээ стандарттай байхыг зорих гол шалтгаануудын нэг мөн” гэсэн байна.

Стандарт яагаад хэрэгтэй гэж

Европын орнууд хүйтэн дайны дараах шилжилтийн үеэс маш хурдацтай хөгжиж, хөгжлийн шинэ шатанд гарсан. Тэд яагаад ийм хурдтай хөгжиж чадсан бэ. Хариулт нь Европын холбооны орнуудад хийгдсэн стандартын шинэчлэл чухал нөлөө үзүүлсэн гэж үздэг. 1993 оны Маастрихтийн гэрээгээр Европын холбоо парламенттай, нэгдсэн валюттай болж улмаар нэг хил хязгаартай болсон. Түүнчлэн зүүн Европын бүх орныг өөртөө нэгтгэж чадсан. Гэхдээ хамгийн чухал нь Европын нэгдсэн стандартыг баталсан явдал юм. Гишүүн орнуудад тогтсон ижил стандарт мөрдөнө, тэр нь дэлхийн хамгийн дээд түвшин байх учиртай. Сургалт, эмнэлгийн үйлчилгээ, хүнсний аюулгүй байдал, хот төлөвлөлт гээд бүх зүйл нь өндөр түвшний стандарттай. Тэр стандартад л нийцүүлж чадахгүй бол Европын холбоо хүлээж авахгүй “бака, чау” гэнэ.

Европын холбооны улсууд энэ мэт өөрсдөдөө төдийгүй дэлхий дахинаа өндөр стандарт тогтоосон нь чанар хэмээх ойлголтыг араасаа дагуулсан. Тухайлбал, дэлхийн аль ч өнцөгт Герман гэх нэрийг сонсоод хамгийн түрүүнд чанар бодогддог. Тиймээс л тэдэнд итгэх дэлхий нийтийн итгэл хамгийн өндөр байдаг гэнэ.

Чанарын талаар цухасхан

Чанарын тухай тогтсон тодорхойлолт байдаггүй ажээ. Харин хүн өөртөө зориулан ашигтай шинжүүдийг түүвэрлэн авч түүнийгээ засаж залруулж, тохируулж болох өөрөөр хэлбэл, стандартчилж болох. Түүнчлэн удирдан жолоодох боломжуудын нийлбэр байж болно гэж үздэг байна. Үүний тулд ашгийн болоод хөгжлийн төлөө явж байгаа бизнесийн байгууллагаас эхлээд аливаа улс, төр, засаг чанартай байхын тулд төлөвлөж, хянаж,

ISO 9001

ДЭЛХИЙН 1.1 САЯ БАЙГУУЛЛАГА ДЭЭРХ СТАНДАРТЫГ МӨРДДӨГ

сайжруулан, засаж залруулах ажлыг тасралтгүй хийдэг. Ямартай ч стандарт, чанар гэх хоёр ухагдахуун өөр өөр ойлголт хэдий ч нэгийг нөгөөгөөс нь салгаж болохгүй юм. Linde Engineering Dresden GmbH компанийн борлуулалт маркетингийн хэлтсийн дарга Norbert Kiene Герман Монголын бизнесийн өдрүүд чуулга уулзалтын үеэр “Чанар зарим талаар гарт баригдахгүй, нүдэнд харагдахгүй боловч дэлхий нийт стандарт тогтоох, түүнийг баталгаажуулах аргачлалын үндсэн дээр чанарыг бодит зүйл болгож чаджээ. Түүний нэг нь дэлхий нийтийн сайн мэддэг ISO стандарт юм” гэв.

Амжилтыг юугаар хэмждэг вэ?

Бизнес ба худалдан авагчийн аль алиных нь сонгодог хэмжүүр нь чанар юм. Компанийн удирдлага, үйлдвэрлэлт, хяналт өөр юу ч байсан эдгээр арга ажиллагааны цаад зорилго нь бараа, бүтээгдэхүүнийг хүртэгч буюу үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, нийлүүлэгчийн үйлчилгээг сайжруулахад оршдог аж. Үүнийг товчхондоо чанар гэж нэрлэдэг. Чанар гэдэг нь нэлээд субъектив үнэлгээ. Тухайлбал, чанартай үйлчилгээний талаар таны ойлголт таны үйлчлүүлсэн хүнсний дэлгүүрийн бас нэг үйлчлүүгчийнхээс өөр байж болох юм. Улаанбаатар дахь хүнсний дэлгүүрийн чанарын стандарт Дархан эсвэл Эрдэнэт хотуудынхаас өөр байж болно. Тиймээс энэ ойлголтыг цэгцлэх зарим талаар нэгтгэх

хэрэгтэй. Харин энэ асуудлыг дэлхий дахинаа ISO зохицуулдаг. Олон улсын стандартжуулалтын байгууллага / ОУСБ/-аас боловсруулсан “ISO 9001” стандартыг дэлхийн 1.1 сая байгууллага авсан байх жишээтэй. Үүний гол учир нь ISO нь дэлхий дахины олон стандартыг өөртөө нэгтгэн “Чанарын баталгаа” хэмээх тогтолцоог тодорхойлдог талаар ОУСБ-ын хөгжил боловсролын нэгжийн дарга Veer Vadoo Герман, Монголын бизнесийн өдрүүд чуулга уулзалтын үеэр тавьсан илтгэлдээ дурдсан юм. ОУСБ нь дэлхийн 100 гаруй улсын стандартын төлөөлөгчөөс бүрддэг. Зорилго нь дэлхий дахинаа бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын солилцоог хөхүүлэн дэмжих, оюуны, шинжлэх ухаан, технологийн болон эдийн засгийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршдог байна. Түүнчлэн олон улсад уг стандартыг хэрэглэх зайлшгүй шаардлага тулгардаг аж. Эх дэлхий даяаршиж байгаа өнөө үед ашгийн төлөөх ямар ч байгууллагад дэлхийн зах зээл нээлттэй. Харин тэр зах зээлд гарахын тулд хамгийн түрүүнд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх хэрэгтэй. Харин чанарыг дэлхий нийт ISO гэх мэт олон нийт хүлээн зөвшөөрсөн стандартаар хэмждэг болсон.

Монгол чанар

Манай улсын эдийн засгийн өсөлт дэлхий нийтийн атаархлыг төрүүлж байгаа нь нууц биш. Тэр ч утгаараа Монгол улс олон улсын хөрөнгө оруулагчдын анхаарлыг хамгийн их татаад байгаа. Монголчууд ч ялгаагүй гаднын хөрөнгө оруулалтыг татахын тулд ихээхэн чармайж буй. Гэхдээ бидний алсын зорилго бол монголчууд өөрсдөө дэлхийн зах зээл дээр гарч өрсөлдөх явдал билээ. “Үндэсний брэндийн маркетинг” хөтөлбөрийн удирдагч Stephen Kreppel “Өнөөдөр гаднын ихэнх оронд Монголын талаар сайн, муу ямар ч ойлголт байхгүй. Тухайлбал, Хятад улс найдвартай гэх үзэл бодлыг дэлхийн хэрэглэгчдийн тархинд нь суулгаж чадаагүй. Үнэхээр найдвартай бараа үйлдвэрлэсэн ч худалдан ►

► авагчид шууд хүлээн зөвшөөрөхгүй. Харин Герман, Япон зэрэг улс өөрсдийгөө илүү найдвартай гэдгийг олон улсад таниулж чадсан. Тиймээс лангуун дээрх бүх бараа адилхан чанартай, үнэтэй байлаа ч худалдан авагчид Германы бүтээгдэхүүнийг сонгодог. Харин Монголын талаар найдвартай аль эсвэл найдваргүй гэх ойлголтын аль аль нь гаднынхны дунд байхгүй. Энэ бол том давуу тал. Тиймээс Монгол улсад үйлдвэрлэсэн юм бүхэн найдвартай гэх ойлголтыг бий болгох хэрэгтэй” гэв. Үүнийг бий болгохын тулд хамгийн түрүүнд дотооддоо үйлдвэрлэгч орон болох хэрэгтэй бөгөөд тэр үйлдвэрлэсэн

бараа, бүтээгдэхүүнээ дээрх мэт олон улсын стандартад нийцсэн стандартаар баталгаажуулах хэрэгтэй. Гэхдээ өндөр хөгжилд хүрсэн Герман, Швейцарь зэрэг орны бараа, бүтээгдэхүүнд ISO гэх мэт чанарын стандартын гэрчилгээ хэрэггүй байдаг аж. Учир нь тэд нэгэнтээ дэлхий нийтийн итгэлийг олсонд бүх учир оршдог. Харин тэр их итгэлийг олох эхний алхам бол дэлхий нийтийн стандартыг дотооддоо нэвтрүүлэх юм. Өдгөө органик буюу “ногоон” бүтээгдэхүүн хэрэглэгчдийг татах хамгийн гол хөшүүрэг болоод байна. Энэ үед байгальтайгаа зохицож амьдардаг нүүдэлчин монголчуудын

энгийн амьдрал л өөрөө олон улсад брэнд болох боломжтой. Гэхдээ хамгийн чухал асуудал нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн дэлхийн стандартад нийцсэн байх учиртай. Өнөөдөр Монголд үйлдвэрлэсэн ноолууран цамцны шошгонд 100 хувь ноолуур гэж бичээд хэн ч итгэхгүй. Учир нь өнөөдөр бүх л ноолууран цамц 100 хувь гэсэн бичигтэй байгаа шүү дээ. Харин бид шошгон дээр бичсэн 100 хувь гэсэн үгийг баталгаажуулахын тулд хамгийн түрүүнд дэлхийн хэмжээний стандартын шаардлага хангасан гэдгээ нотлох хэрэгтэй. Ингэж чадвал дэлхий нийт биднийг хүлээн авна. ■

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

УЛАМЖЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН АЛЬ НЬ ВЭ

И.ОТГОНЖАРГАЛ

...Махны технологи, үйлдвэрлэл өндөр хөгжсөн Герман улсад хувийн мал, амьтантай фермерүүд манайхан шиг хүссэн үедээ сүргээсээ дураараа нядлах эрхгүй...

Монгол хүн шинэ шөл оочих, бяцхан үүрсдээ “бөөр, зүрх гаргаж” өгөхийг хүсвэл дуртай үедээ хоттой хониноосоо барьж аваад л зооглодог. Герман улсад фермийн аж ахуй эрхлэгчид манайхан шиг хүссэн үедээ сүргээсээ дураараа нядлах эрх байдаггүй. Махны эрүүл ахуй ариун цэвэр, аюулгүй байдлын стандартын дагуу заавал үйлдвэрт өгч төхөөрүүлэх хуультай байх жишээтэй. Эндээс үзэхэд Монголын уламжлалт мал нядалгаа, махны үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэврийн стандарт дэлхийн жишгээс тэс хөндлөн явна. Мах нь түргэн мууддаг, бохирдож, нян вирус үржих эрсдэл өндөртэй бүтээгдэхүүн гэгддэг. Хүнсний үйлдвэрлэл, технологийн чиглэлийн наад захын сурах бичгээс ч энэ талаар олж

мэдэхэд төвөггүй. Тийм ч учраас дэлхийд мал төхөөрөх үйлдвэр, мах, махан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд дээд зэргээр анхаарч, эрүүл ахуй, ариун цэврийн холбогдох дүрэм журам, стандартуудыг чандлан мөрддөг учиртай.

ХБНГУ мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмжийн чанараараа дэлхийд тэргүүлдэг. Өнгөрсөн сард Улаанбаатарт болсон “Герман-Монголын бизнесийн өдрүүд” чуулга уулзалтын үеэр яригдсан нэг сэдэв нь мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шинэчлэл, технологи, чанарын асуудал байсан юм. Эхний илтгэлийг тавьсан “Хаммер Дорфмарк” компанийн захирал Жозеф Хаммер “Амьдралд нийцтэй технологи, дээд ►



► зэргийн ариун цэвэр, олон жилийн туршлага, үе дамжин уламжилж ирсэн арга барил, орчин цагийн шинэчлэл гээд энэ бүхэн Германы мах үйлдвэрлэлийн салбарыг тодорхойлж өгдөг” гэсэн юм. Тэрбээр өдгөө махны үйлдвэрлэлийн тоног, төхөөрөмж худалдаалдаг бизнес эрхэлдэг. Туршлагатай технологчийн сонирхуулсан статистик мэдээллээс үзэхэд, ХБНГУ-д мах, махан бүтээгдэхүүний олон жижиг үйлдвэр байсан нь хөгжлийн явцад эрүүл ахуй, ариун цэврийн чанар стандартын шаардлагын дагуу том үйлдвэрүүддээ шахагдаж цөөрчээ. Гэхдээ тус улс энэ салбарын ололт амжилтаа улам сайжруулж, дэлхийн жишиг болж яваа учраас өдгөө махны үйлдвэрлэлийн тархалт буцаад хүрээгээ тэлэх хандлага бий аж. Монголд ч мөн нийгмийн хөгжлөө дагаад иргэдийн хүнсний бүтээгдэхүүнд тавих эрүүл ахуйн шаардлага, хэрэглээний соёл өөрчлөгдөж буй. Тиймээс мал төхөөрөх монгол арга цаг үеийн шаардлагаар өөрчлөгдөхөөс аргагүй. Монголын мах, махан бүтээгдэхүүний

үйлдвэрлэлтэй холбоотой статистик өгүүлье. Монгол улс жилд дунджаар 8.0 сая гаруй толгой мал хүнсэнд хэрэглэж, 200-240 орчим мянган тонн мах үйлдвэрлэж, дотоодын хүн амын хэрэгцээгээ бүрэн хангаж байна. Өнгөрсөн онд гэхэд л улсын хэмжээнд нийт 208 мянган тонн мах бэлтгэсний 15,6 мянган тонныг нь үйлдвэрийн аргаар боловсруулжээ. Холбогдох албаны мэдээлэлд дурдснаар энэ нь тийм ч чамлахаар үзүүлэлт биш гэнэ. Учир нь дээрх үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний хэмжээ өмнөхөныхоос 1.9 хувиар, 2008 онтой харьцуулахад 26,8 хувиар тус тус өсчээ. Түүнчлэн хиамны төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл мөн онд 2204.4 тн буюу өмнөх онтой харьцуулахад 27 хувиар өссөн дүнтэй байна. Харин үхрийн махны үйлдвэрлэл өмнөх оноос 25 хувиар буурсан бол бусад малын махны үйлдвэрлэлийн хэмжээ 10-70 хувиар нэмэгджээ.

Манай улсад том, жижиг нийлсэн нийт махны 42 үйлдвэр бий. Эдгээр үйлдвэр жилдээ 18620 толгой бог,

3600 бод төхөөрөх, 30237 тн мах хөргөх, 1160.2 тн-ын хөлдөөх хүчин чадалтай тухай Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны 2008-2012 оны махны салбарын тайланд дурджээ. Дээрх 40 гаруй үйлдвэрээс 10 гаруйхан нь тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг. Энэ нь мал нядлах технологи, мал эмнэлэг, ариун цэврийн стандартын шаардлага хангахгүй, Аюлгүйн дүн шинжилгээ буюу эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо/НАССР/ нэвтрүүлээгүйтэй холбоотой гэж үзэж болох юм. Тухайлбал, 2010 онд Хүнс, хөдөө аж ахуйн яам /өмнөх нэрээр/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын удирдлагуудын гаргасан холбогдох тушаал, удирдамжийн дагуу улсын хэмжээний мал нядлах, мах боловсруулах 35 үйлдвэрт мал нядлах технологи, мал эмнэлэг, ариун цэврийн байдалд хянан магадлагаа хийж, дүгнэлт гаргажээ. Зургаан үйлдвэр “AAA”, 28 үйлдвэр “AA” зэрэглэлийн шаардлага хангасан бол нэг үйлдвэрийн “AA” зэрэглэлийг цуцалсан аж. Дэлхий нийтэд чухлаар авч үзэж буй махны үйлдвэрийн ►

► Аюулгүйн дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог “Жаст-Мах маркет” үйлдвэр өнгөрсөн онд нэвтрүүлж, олон улсын байгууллагаас итгэмжлэл авсан. Ингэснээр манайх мах, махан бүтээгдэхүүнээ дэлхийн хөгжингүй улс орнуудад экспортлох боломж бүрдэж байгаа гэж мэргэжилтнүүд онцолдог. Мөн дээрх “Герман-Монголын бизнесийн өдрүүд” чуулга уулзалтын үеэр махны чиглэлийн хоёр дахь илтгэлийг НҮБ-ын ХХААБ /FAO/-ын “Махны чанар, аюулгүй байдлыг сайжруулах” GCP/MON/007/ITA төслийн үндэсний зохицуулагч С.Энхбаяр тавьсан.

Итали улсын Засгийн газрын “Итгэлцлэлийн сан”-гаас санхүүжилттэй нийт 520 мянган ам.долларын уг төсөл нь өнгөрсөн оны хоёрдугаар сараас ирэх оны тавдугаар сар хүртэл хэрэгжих аж. Энэ төсөл нь Монголын махны үйлдвэрлэлд үгүйлэгдэж буй Махны аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо буюу /GMP, HACCP/ нэвтрүүлж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах тал дээр богино хугацаанд гарт баригдахаар ажлууд хийж байгаа нь олзуурхуштай байв. GMP гэдэг нь үйлдвэрлэлийн зохистой дадал юм. Тус төслийн хүрээнд HACCP-г Монголын хоёр махны үйлдвэрт

15

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД FAO-ГИЙН “МАХНЫ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛСАН МАХНЫ ЦЕХИЙН ТОО.



Эх сурвалж: УХААЯ

хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байсан ч нэг нь үйлдвэрийн байдлаасаа болоод төдийлэн хийгдээгүй. Харин Дархан-Уул аймагт байрлах “Дархан мийт фүүдс” ХХК-д сайн хэрэгжиж байгаа аж. Аюулгүйн дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо нь сайн тоног төхөөрөмж авч, суурилуулснаар шийдэгдчихгүй. Мал


хүлээж авахаас эхлээд үйлдвэрийн бүх шатанд үйлчилдэг бүртгэлээр хяналт тавих тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл, энэ тогтолцоог нэвтрүүлэхэд төслийн зүгээс нэр дурдагдсан үйлдвэрт очиж сургалт хийх, байнга мэргэжлийн заавар зөвлөгөө өгдөг байна. Үйлдвэрийн удирдлагын зүгээс харин олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт хийхэд гар татахгүй байх “эр зориг” хэрэгтэй. Төслийн удирдагч, зөвлөх “Дархан мийт фүүдс” компанийн захиралд энэ тал дээр онц дүн тавьж байна лээ. Учир нь, тус компани төслийн хугацаанд өөрийн хөрөнгөөр мал нядалгааны шугамаа бүрэн шинэчилж, үйл ажиллагааны хүрээгээ өргөжүүлж мах шулж, ангилж, савлах, хиам болон боловсруулсан бүтээгдэхүүний цех байгуулсан байна. Тус төслийн зөвлөхөөр Мишаел Бенкер гэдэг махны технологич мэргэжилтэй герман хүн ажиллаж, үйлдвэр болоод орон нутагт байгуулж буй махны жижиг цехүүдэд зөвлөж байгаа нь нэлээд үр дүн өгч байгаа ажээ. Мөн тус төслийн хүрээнд аймаг, орон нутагт махны 15 жижиг цех байгуулсан байна. Уул уурхайн хөгжилтэй холбоотой зах зээлд шинээр бий болж буй эрэлт хэрэгцээг малын гаралтай аюулгүй хүнсээр хангах, хөдөө, орон нутагт өртөг шингэсэн бүтээгдэхүүн



► үйлдвэрлэх техникийн чадавхыг сайруулах зорилтын хүрээнд ийн 15 суманд махны жижиг цех барьжээ. Сумын цех мал төхөөрнө-мах боловсруулна-гулууз мах, ангилсан мах, дайвар бүтээгдэхүүн гаргана-төрөл бүрийн хиам, дотор махан бүтээгдэхүүн, бууз, банш гэх мэтийг үйлдвэрлэж аль ойрхон байгаа аймаг, орон нутгийн зах зээлд нийлүүлдэг байна. Ийнхүү мал төхөөрөх, махан бүтээгдэхүүн боловсруулах цех сумын түвшинд байгуулагдана гэдэг бол хот, суурин газраас алслагдсан иргэд эрүүл ахуйн шаардлага хангасан, шинэ хүнсээр хангагдах нөхцөл бүрдэж байгаагаараа ач холбогдолтой юм. Үүнтэй холбоотой сүүлийн үед хөдөөд махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх сонирхол их болсон. Харин сумын цехийн хиамны үйлдвэрлэлд хэрэглэгддэг нитритийн нийлүүлэлтийн асуудлыг цаашид хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх тал дээр төрөөс анхаарах хэрэгтэй гэдгийг Энхбаяр тэмдэглэсэн. Цехийн тоног төхөөрөмжүүдийг төсөл болон ХХААҮЯ/өмнөх нэрээр/наас нийлүүлжээ. Нэг цехэд 37.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж шаардагдах бөгөөд өдөрт таван бод, 20 бог нядлах хүчин чадалтай. Түүнчлэн нэг цехэд доод тал нь дөрвөн хүн ажиллана гэж тооцоход хөдөөд ажлын байр нэмэгдэж байгаа гэсэн үг. Төслийн зүгээс цехийн үйл ажиллагааг эхлүүлэх сургалт, техникийн чадавхыг сайжруулах сумдын нэгдсэн сургалтыг ч мөн цөөнгүй хийсэн байна. Одоо монголчуудад эрүүл, аюулгүй мах хэрэглэж хэвших чиглэлд сурталчилгаа, мэдээлэл өгөх ажил бий тухай Энхбаяр хэлсэн. Хөдөөнийхөн "Бид мал төхөөрөхөө хэнээр ч заалгахгүй мэднэ. Харин махан бүтээгдэхүүн хийх аргад суралцах нь чухал байна" гэж асуудалд өрөөсгөл хандах нь бий талаар төслийнхөн ярьж байсан. Өөрөөр хэлбэл, гар аргаар мал төхөөрөх монгол аргаасаа салах шаардлага байгааг хөдөөний малчид одоогийн байдлаар төдийлэн ойлгоогүй яваа нь эндээс харагдах аж.

Малын төрлөөр үйлдвэрлэлтийн хэмжээ мян/тонн

Бүтээгдэхүүн	2008	2009	2010	2011	2008-2011 Хувь
Үхрийн мах	4274.2	9222.3	5777.7	4324.5	101.1
Хонины мах	3300.3	1852.1	2889.5	4498.7	136.3
Адууны мах	3402.8	6585.3	2337.1	2592.3	76.1
Ямааны мах	1031.9	613.3	1016.8	1748.7	169.4
Хиам	1784.1	1651.6	1734.8	2204.4	123.5



Эх сурвалж: ҮХААЯ

НАССР-ын түүх АНУ-аас үүсэлтэй гэдэг. Европын холбооны улсуудын үйлдвэрлэгчид ч уг тогтолцоог санаачилгаараа нэвтрүүлээгүй юм билээ. Тус орнуудын супер-маркетынхан баталгаатай, найдвартай бүтээгдэхүүн нийлүүлэхийг үйлд- вэрлэгчдээсээ шаардсанаар Европын махны үйлдвэрлэлд энэхүү хяналтын тогтолцоо нэвтэрчээ. Манайд ч

гэсэн супермаркетинхэн худалдан авч буй бараандаа анхаарал тавьж, үйлдвэрлэгчдийг эрүүл, шинэ хүнс нийлүүлэхийг шаардаж эхлэх юм бол Монголын махны салбарт сүүлийн 10-аад жил яригдаад, өдгөө хоёрхон үйлдвэр нэвтрүүлж буй НАССР-г нийтээрээ нэвтрүүлэх боломжтой. Энэхүү эгзэгтэй цэгийн тогтолцоо зөвхөн мах биш, хүнсний бүх үйлдвэрлэлд хамаатай билээ. ■

ЗАЛРУУЛГА

"Mongolian Economy" сэтгүүлийн арваннэгдүгээр сарын эхний дугаарт Монголын бизнесийн зөвлөл /VCM/-ийн ойн баярын талаар "Бизнесийнхний чөлөөт индэр таван нас хүрлээ" гарчигтай сурвалжлага нийтэлсэн билээ. Тус мэдээлэлд манай сэтгүүлчийн буруугаас Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга асан Лоренц Мелчерсийн нэрийг Монголын бизнесийн зөвлөлийн үүсгэн байгуулагчдын нэг Питер Морроутай андуурч баримтын алдаа гаргасанд хүлцэл өчиж, залруулан уншихыг хүсэж байна.

"Mongolian Economy" сэтгүүлийн редакци

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ

ГАЗРЫН ТОСООР ДЭЛХИЙГ ЭЗЛЭХ ҮҮ

Б. ТУЯА

...Монгол улсын шатахууны цангааг тайлагч ОХУ төрийн өмчит “Роснефть” компанийг хувьчлахаар болжээ. Жилд дунджаар 10-12 сая тонн нефть олборлодог тус компанийн зургаан хувийг эхний ээлжинд хувьчлах бөгөөд 2016 он гэхэд бүрэн хувьчлах гэнэ...

“Роснефть” цахим хуудастаа “Үйл ажиллагаагаа шинэчлэн, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх зорилго тавин ажиллана” хэмээн онцолжээ. Хойд туйлд газрын тосны 4.5 сая тонн нөөцтэй ордыг 2010 онд нээсэнтэй холбоотойгоор ирэх онуудад тус компанийн нийлүүлтийн хэмжээ дэлхийн газрын тосны зах зээлд илт нэмэгдэх тооцоо байна. Харин тэд олборлолт хүлээж суухыг хүссэнгүй бололтой.

Английн 50 хувийн эзэмшлийн “ТНК-ВР” газрын тосны компани ОХУ-ын газрын тосны үйлдвэрлэлийн 16 хувийг бүрдүүлдэг. Сүүлийн саруудад дуудагдах болсон “Роснефть” тус компанийг худалдаж авах нь гэх цуу яриа үнэний ортой байлаа. ОХУ-ын төрийн өмчит компанийн удирдлагууд Английн British Petroleum (BP) газрын тосны “акул”-тай хэлэлцээрийн ширээнд сууж, тус компанийн хувьцааг 17.1 тэрбум ам.доллараар “өөрийн” болгох гэрээг үзэглэсэн юм. Ингэснээр “Роснефть”-ийн газрын тосны үйлдвэрлэл 16 хувиар өсөж байгаа аж. Түүнчлэн “Консорциум ААА”-ын мэдлийн үлдсэн 50 хувийг 28 тэрбум ам.доллараар худалдаж авахаар болжээ. Ийнхүү тус


компани “ТНК-ВР” компанийг 100 хувь эзэмшиж, улмаар дэлхийн нефтийн бүтээгдэхүүний зах зээлд тэргүүлэгчдийн нэг болж байгаа юм.

Тэргүүлэхэд төлөөс нь юу вэ?

ОХУ-ын хувьд дээрх гэрээг тун ашигтай нөхцөлөөр хийсэн гэх. Дотоодын гурав дахь том газрын тосны үйлдвэрлэгчийг “Роснефть”-ээр овоглох амаргүй байсан биз. Гэрээний дүнд “Роснефть” компанийнхаа 12.84 хувь, улсын мэдлийн 76 хувийн 5.66 хувийг харийн гарт өгөх болсон бөгөөд цаашид ч алдах магадлалтай. Орос ахан дүүсийн эл шийдвэр зөв эсэхээр олон улсын шинжээчид маргаж дуусаагүй л байна.

Зээл, хөрөнгийн сангаас санхүүжилт босгохоор төлөвлөсөн тус компанид Английн мэдлэг, чадвартай нефтийн мэргэжилтнүүдийн тусламж хэрэгтэй нь тодорхой. Хувьчлах нэрээр тэдний ур чадварыг “хувьчлах” стратеги хэрэгжүүлж байна гэх шинжээчид ч байгаа юм. Учир нь 2010 онд олборлолт, үйлдвэрлэл нь дундаж хэмжээнээс 6.2 хувиар унасан, улмаар Standard & Poor’s “Роснефть”-

ийн үнэлгээг “BBB-” зэрэглэл рүү бууруулсан нь тус компанийн удирдлагуудын хувьд хатуухан алганы амт болсон юм. Иймээс тэд дотоодын төдийгүй дэлхийн нефтийн бүтээгдэхүүний зах зээлд нэр хүндээ сэргээхийг эрхэмлэх болов. Хамгийн сүүлд үзэглэсэн гэрээ, урд хөршид 13 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барих төсөл гээд хүрээгээ тэлэх бүхий л аргыг хэрэгжүүлэхээр зориг шулуудсан юм. “Роснефть дэлхийн эдийн засаг болон өрсөлдөөний салбарт хүч түрэн орно” хэмээн ОХУ-ын Эдийн засаг хөгжлийн яамны сайд Андрей Белоусов онцолсон удаатай. Сайдын хэлснээр “Роснефть”-ийг хувьчлах асуудал тус компанийн тэргүүлэх байр суурьт нөлөөлөхгүй аж. Үйлдвэрлэл, нөөц, капиталаараа дэлхийд цойлох тус компани ОХУ-ын үндэсний ашиг, сонирхол болон өрсөлдөх чадварыг ахиулах гол “хэрэгсэл” болж байгааг тэрбээр хэлсэн байдаг. ОХУ-ын Ерөнхийлөгч Путин “Роснефть”-ийн захирал Игор Сечинтэй хийсэн уулзалтынхаа үеэр “ТНК-ВР компанийг худалдан авах гэрээ мөн “Роснефть”-ийн зургаан хувийг ирэх онд хувьчлах хэлэлцээрүүд дотоодын эрчим хүчний салбарт төдийгүй улсын эдийн засгийн өсөлтийн хувьд чухал үүрэгтэй” хэмээн онцолжээ. Тэрбээр “British Petroleum гэрээнд гарын үсэг зурсан нь барууны түншүүд бидэнд итгэж байгаагийн илрэл” гэж олзуурхсан байна. ▶



► Ирээдүйд...

“Роснефть” компани жилд нийт олборлолтынхоо 53.6 хувийг экспортолдог. Үүний 98.8 хувийг Тусгаар улсуудын холбооны бус орнуудад нийлүүлдэг байна. Дээрх 98.8 хувийн 52 хувь нь түлш, 32 хувь нь дизель түлш байдаг бол 12 хувь нь керосин аж. 2010 оны байдлаар нийт 25.81 сая тонн газрын тос экспортолсны 10.12 сая тонныг Азид нийлүүлжээ.

Харин “ТНК-ВР” компанийг элсүүлсэн тул дээрх тоо нэмэгдсээр байх аж. Дэлхийн нефтийн бүтээгдэхүүний дийлэнх хувийг үйлдвэрлэх “Роснефть” зорьсон нэр хүндийг олохын зэрэгцээ дэвшилт технологийг нэвтрүүлэх нь гарцаагүй. Энэ талаар санхүүгийн зах зээлийн шинжээч Витали Крюков “Роснефть хайгуулын маш олон төсөл хэрэгжүүлдэг. Харин одоогоор хамгийн томд тооцогдож байгаа нь Хойд туйлд илрүүлсэн ордын олборлолтын ажил. Английн газрын тосны компанитай хамтрах болсон нь олборлолтыг түргэсгэх сайхан боломж. Хойд туйлын тэсгэм хүйтэнд нефть олборлоно гэдэг амаргүй. Гэхдээ тэд энэ ажлыг гаднын

10.7 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

РОСНЕФТИЙН 2006
ОНД БОСГОСОН
ХӨРӨНГӨ /ИРО/

мэргэжилтнүүдээр хялбар хийлгэх арга олсон” хэмээн ярьсан байна.

Төрийн өмчит “Роснефть” компанид Хойд туйлд газрын тосны хайгуул хийх ОХУ-ын зөвшөөрлийн 75 хувийг олгохыг Ерөнхийлөгч Путин үүрэгджээ. Ингэснээр гадаадын болон дотоодын компаниуд тус хэсэгт ямар нэг үйл ажиллагаа явуулах бол “Роснефть”-ээс зөвшөөрөл авч, гэрээ байгуулах ёстой болж байгаа юм. Харин байгалийн хий олборлох байгууллагууд ОХУ-ын төрийн өмчит “Газпром”-ын үгээр байх шаардлагатай ажээ.


Энэ оны гуравдугаар улирлын дүнгээр “Роснефть” 5.77 тэрбум ам.долларын ашигтай ажилласан

байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 30 гаруй хувиар өссөн үзүүлэлт юм. Ганц жилийн дотор ашгаа ийнхүү нэмэгдүүлж чадсан тус компани дэлхийг хэрэх экспортын замаа өргөсгөж байгаагийн нэг илрэл хэмээн шинжээчид дуу нэгтэй дүгнэж байна.

“2012 оны гурав дахь улирлын дүн эерэг гарсан нь манай компани зардлаа багасгаж, хүртээмжийг чухалчилж ажилласны үр дүн” хэмээн “Роснефть”-ийн захирал Игор хэлжээ. Харин тус компанийн санхүүгийн дэд захирал Димитри Авдийв “ТНК-ВР компанийг худалдаж авснаар бид үйлдвэрлэлийн зардлаа багасгах боломжтой болсон. Цаашид ч энэ зарчмаар үйл ажиллагаагаа явуулна. Харин хэмнэсэн мөнгөө байгууллагынхаа логистик болоод төслийн хэрэгжилтийг сайжруулах, захиргааны урсгал зардлыг багасгах зэрэгт төвлөрүүлнэ” гэжээ.

ОХУ-ын нефтийн бүтээгдэхүүний 40 хувийг бүрдүүлэх эл компанийн ирээдүй гэрэлтэй байна. Өдөрт 2.73 сая баррель газрын тос үйлдвэрлэх хүчин чадалтай болсон тус компани дээрх тооцоог ирэх онд хоёр хувиар нэмэгдүүлнэ хэмээн газрын тосны салбарын шинжээчид гаргаад байна. ■

АСУУДАЛ



ҮГ БИШ

...Эдийн засгийн өсөлтөөрөө гайхуулж буй орнуудын нэг нь Монгол. Түүний агуу их өсөлтийн гол хөдөлгүүр нь уул уурхай. Харин хөдөлгүүрийн чухал “зэмсэг” нь нефтийн бүтээгдэхүүн. Гэтэл манай улсыг хоолтой нь залгуулах эл стратегийн бүтээгдэхүүний хангамж, нөөцийн асуудал улам хүндрэх төлөвтэйдэг ээ...

ҮЙЛДЭЛ ХАРУУЛНА

Б. ҮҮРИЙНТУЯА

Хойд хөршийн стратегийн салбаруудад хувьчлалын “аян” өрнөж эхлээд байна. Төрийн өмчит өсөн байгууллагыг хувьчлахаар тус улсын Засгийн газар шийдвэрлэсний нэг нь манай улсын нефтийн бүтээгдэхүүний гол нийлүүлэгч “Роснефть” юм. Ирэх онд тус компанийн зургаан хувийг хувьд шилжүүлэхээр тогтжээ.

“Олон хавар нэгэндээ” гэдэгчлэн нефтийн бүтээгдэхүүний хараат байдлаа багасгах талаар чихэнд тод, нүдэнд ил зүйл хийхгүй бол нийлүүлэлтийн байдал улам бүр хүндрэх төлөвтэйг газрын тосны мэргэжилтнүүд санаа зовионг сануулах болжээ. Жолооч нар ч байн байн шатахуун түгээх станцад урт дараалал үүсдэг болох нь ээ гэсэн болгоомжлол тээх боллоо. Нефтийн бүтээгдэхүүний хангамжийн

асуудлуудыг нэг л тайван биш болгож орхив. Гэтэл шаваа тавиад нэгэн жарныг үдсэн Монгол улсын газрын тосны салбар ОХУ-ын “Роснефть” компанийн “атганд” ороод багагүй хугацаа үдэж буй. Монгол улсыг шатахуунаар тэтгэгч ОХУ нефтийн бүтээгдэхүүний экспортын үнээ өөрчлөх төдийд манай Засгийн газар тэвдэж эхэлдэг. Дотооддоо нефть боловсруулах үйлдвэр байгуулна хэмээн мөрөөдөхөөс цаашгүй улсад орос ахан дүүс жил ирэх тусам хатуурхах болжээ. Тэдний алганы амтыг хэдэнтэй хүртсэн Монгол улс урд хормойгоороо ардахаа нөхдөг гал унтраасан аргаар хэр хол явах вэ. Шатахууны үнийн асуудал дахин боссонтой холбоотой өмнөх Засгийн газрын нефтийн үйлдвэртэй болох мөрөөдлийг Шинэчлэлийн Засгийн газар хаашаа залах бол гэх хүлээлт

нийгэмд бий болов.

Домог болсон боловсруулах үйлдвэрийн төслүүдийг тоосонд даруулах уу, эсвэл хэрэгжүүлэхээр зорих уу гэдэг тодорхойгүй байна. Үнийн дарамтыг иргэддээ үрүүлэхгүй нэрээр ямартай ч эхний ээлжинд дотоодын нефтийн бүтээгдэхүүн импортлогч компаниудад 120 сая ам.долларын зээл олгохоор болсон. Харин үнийг оны сүүлчийг нэр төртэй үдэх гэсэн төрийн PR гэх нэг хэсэг байхад нөгөө хэсэг нь шатахууны үнийг тогтвортой барих сонгодог арга хэмээн олзуурхаж байна.

Айлаас эрэхээр авдраа уудал

Монгол улсын газрын тосны мэдэгдэж байгаа нөөцийг 1.6 тэрбум тонн гэх. Батлагдсан нь 196 сая тонн. ▶▶

► Үүний 30 сая тонныг шууд олборлох боломжтой. Энэ нөөцийг ашиглах талаар мэргэжилтэн, судлаачид мэтгэлздэг. Чулуу болгоё гэвэл тийм ч чамлалттай нөөц биш гэдэг. Нэг үгээр, төр авдрынхаа цоожийг зөв түлхүүрдэж чадвал хойд хөршид шатахууны үнэ нэмэгдэх сургаар дагжин суух хэрэггүй болох аж. Гэхдээ уухад учир бий. Баримтаас үзэхэд, Монгол улсад газрын тосны хайгуулын 30 талбай байдаг. Эдгээрийн 18 талбайд гадаад, дотоодын 14 компани үйл ажиллагаа явуулж байна. Үлдсэн талбайд холбогдох тендерийн сонгон шалгаруулалт явуулсан байдаг ч Засгийн газраас хайгуулын зөвшөөрөл олгоогүйн улмаас цаасан дээр л хэрэгжих болов.

Газрын тосны хайгуулын ажил багагүй хугацаа, чамгүй хөрөнгө шаарддаг тухай мэргэжлийн хүмүүс учирладаг. Нарийн дурдвал зөвхөн хайгуул хийхэд хамгийн багадаа 30 сая ам.долларын хөрөнгө оруулалт, 4-5 жилийн хөдөлмөр шаарддаг бол олборлолтод 100 сая ам.доллар зарцуулах нь энүүхэнд. Нефть олборлож буй Тамсагийн болон Зүүнбаянгийн сав газарт өнөөдрийн байдлаар 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн гэх тоо байна. Гэсэн ч энэ нь дотоодын бүү хэл, бүс нутгийн шатахууны хэрэгцээг хангахад хүрэлцэхгүйг салбарынхан хэлдэг. Арга ч үгүй биз. Нэг цооногийг л гэхэд 4000 хүртэлх метрийн гүнд өрөмдөж, хоёр сая ам.доллар зарцуулдаг ажээ. Иймд манай улсын газрын тосны нөөцийг бүрэн ашиглахын тулд асар их хөрөнгө шаардлагатай юм.

Манайд ирээрэй гэж урьчихаад...

Газрын тосны салбарт хөрөнгө оруулах хүсэлтэй “томчууд” олон байдаг. Гэвч манайхан “Тавтай морил” хэмээн урьчихаад эзэнгүй мэт үүдээ нээдэггүй нь хачирхалтай.

Тус салбарт хөрөнгө татах гол хүчин зүйлсийн нэг нь нөөц. Дэлхийн жишигт 10 цооногийн 1-2 цооног нь газрын тостой гарвал “аз” гэж үздэг аж. Харин манай орны хувьд 10 цооногийн талаас илүү хувь нь

6 ЭНЭ ОНЫ ЭХНИЙ ДОЛООН САРЫН БАЙДЛААР ИМПОРТЫН ӨСӨЛТИЙН 15 ХУВИЙН ХУВИЙГ НЕФТИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨСӨЛТ БҮРДҮҮЛЖЭЭ

тостой гардаг байна. Дээрх баримтыг нийт талбайн 3-4 талбайн нөөц дээр үндэслэсэн байдаг ажээ. Иймд үлдсэн хайгуулын талбай хэр хэмжээний гарзын тос “нууж” байгааг тогтоовол бэл бэнчинтэйг нь “уургалах” амархан. Гагцхүү галын дөлийг унтраах биш, дүрэлзтэл нь асаах чухал. Гэтэл төрийн механизмаар хөдөлгөх учиртай эл салбарыг Засгийн газар үгээрээ дэмжээд үйлдлээрээ “боох” болж. Энэ салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд тэргүүнд анхаарах зүйл бол хууль, эрх зүйн орчин. Ардчилал ид цэцэглэж байхад “Газрын тосны пүүс” хэмээх байгууллага үүсэж, одоогийн Газрын тосны газрын суурийг тавьж байжээ. Ийнхүү 1991 онд Монгол улс Газрын тосны тухай хуулиа баталсан түүхтэй. Дэлхийн сонгодог арван хуульд үндэслэн тус хуулийг боловсруулж, Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарчмыг тусгасан нь сайн болсон гэж салбарын мэргэжилтнүүд нь онцолдог. Гэвч зах зээлийн шаардлагын дагуу тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэйг ч тэд учирласаар байна.

Гарц бий юу

Аливаа бүтээгдэхүүний ханш зах зээлээсээ хамаарч хэлбэлзэх нь бий. Харин импортын бүтээгдэхүүнээр хоногийн хоолтойгоо золгодог улсад энэ нь хатуухан сургамж болох нь олонтаа.

Монгол улс ОХУ-аас нефтийн бүтээгдэхүүний хараат байдлаа багасгаж, дотооддоо нефть боловсруулах үйлдвэр барина гэх том зорилт тавьсан ч ажил болголтгүй удаж буй. “Газрын тосны үйлдвэр байгуулахтай холбогдсон асуудлаар Уул уурхайн яамнаас танилцуулга хийлээ. Үүнтэй холбогдуулан Газрын тосны үйлдвэрийн Техник, эдийн

засгийн үндэслэл боловсруулах ажлыг яаравчлан шийдвэрлэж, Засгийн газрын хуралдаанд оруулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт үүрэг болголоо” гэх албаны мэдээллээс өөр шинэ зүйл одоогоор алга. Холбогдох салбарынхан нь ч ам жимийгээстэй.

Өнгөрсөн хугацаанд газрын тос боловсруулах үйлдвэр барих төслүүд шил шилээ даган гарсан ч хөрсөнд буусан нь үгүй. Хэрэгжих хамгийн боломжит төслийг “ХЭТ” ХХК-ийн Дорнод аймагт барих 98 хувийн бүтээгдэхүүн гаргах 121 мянган тоннын хүчин чадалтай газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл гэж салбарын төлөөлөгчид үзэж байна. Эл үйлдвэрт 50 сая орчим ам.доллар шаардлагатай аж. Нөгөө талд олон жил яригдаж буй мөнөөх “Намжимын” гэх Японы хөрөнгө оруулалттай Дарханд барих үйлдвэрийн төсөл “түүх” болж байна. Түүнчлэн өмнөх Засгийн газрын үед 34 хувийн төрийн өмчит “Дорнод газрын тос” компанийг байгуулж байсан ч өнөөдөр удирдлагагүй байх жишээтэй. Энэ мэтээр газрын тосны үйлдвэр барих төслүүд замхарсаар байгааг төр, засаг анхааралдаа авах цаг нэгэнт болсон баймаар. Монгол улсын Ерөнхийлөгч асан П.Очирбат News.mn цахим хуудаст өгсөн ярилцлагадаа “Үйлдвэр гэхээр том, нүсэр барилга байшин хэрэггүй. Тамсагийн нефтийн орд, Зүүнбаянгийн Цагаан элсний орд зэрэг газарт байгуулахад болохгүй зүйлгүй. Эсвэл бүр төвлөрсөн газар ч байгуулж түүхий эдээ зөөх маягаар ашиглаж болно. Үүнийг хийх л хэрэгтэй. Түүнээс биш, манайхан дэлхийд шинэ зүйл нээчих юм биш. 500 сая ам.доллартай байхад ямар ч үйлдвэр барьж, байгуулж болно” гэжээ.

Геологийн бүтцээс шалтгаалаад газрын тос олборлоход бэрх Монголын нутаг нүүрсээр баян. ►

Хар алтаа ашиглаад /нүүрс шингэрүүлэх технологи/ шатахууны хэрэгцээгээ хангах боломжтой гэж үзэх мэргэжилтэн ч олон бий. Бас л сонирхолтой хувилбар. Гэтэл дэлхийн тавцанд туршилтын шатанд яваа энэ аргыг Монголд “нутагшуулна” гэдэг ойрын хэдэн зуун дамжих амны зугаа гэх хүмүүс байна. Урд хөрш эл технологийг амжилттай нэвтрүүлж байна хэмээн мэдээлдэг боловч бодит төрх нь урагшгүй байгааг олон улсын шинжээчид тайлбарласан байдаг аж. Хүрэн нүүрснээс шингэн түлш гаргах дээрх аргыг хэрэгжүүлэх нэг бус төслийг Монголын томоохон компаниуд олон улсын хөрөнгө оруулагчидтай хамтран эхлүүлсэн.

Шатахууны үнийн дарамтаас салах бас нэгэн арга бол улсын

нөөц бүрдүүлэх юм. Боловсруулах үйлдвэртэй орнуудын хувьд улсын нөөцийг түүхий тосоор хадгалдаг байна. Тухайлбал, Япон улс нөөцийн хэмжээгээ 240 хоног хэмээн хуулчсан байдаг ажээ. Харин Монгол улсын хувьд түүхий тос хадгалах байгууламж байдаггүй.

Манай улсын шатахууны жилийн дундаж хэрэглээ нэг сая тонн гэдэг. Хэдийгээр жилийн дундаж хэрэглээнийхээ тал хувийг нөөцлөх боломжтой боловч манай улсад тэр хэмжээний шатахуун худалдан авах хөрөнгө байхгүй аж. Хуулиндаа 60 хоногийн түлшний нөөц бүрдүүлнэ гээд заачихсан байдаг. Гэвч ердөө 44 хоногийн нөөц байгааг дүгнэвэл бэлэн бүтээгдэхүүний сав нь байв ч саалиа хураах

мөнгөгүй Монголын Засгийн газар нефтийн бүтээгдэхүүний хараат байдлаасаа ангижрахыг төдийлэн хүсэхгүй байх шиг. Өнгөрсөн онд баталсан “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-д нефтийн бүтээгдэхүүний хангамж, хэрэгцээг зохицуулах тал дээр тодорхой заалтууд оруулсан байдаг. Үүнд тус салбарт ажиллах мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, сан байгуулах гээд гэрэл, гэгээтэй ирээдүйг зөгнөсөн зорилго олныг тусгажээ. Харамсалтай нь дээр дурдсан асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхгүй бол хангамжийн асуудал төдийгүй дотооддоо боловсруулах үйлдвэртэй болно гэдэг ахиад л үлгэр болох тухай учир мэдэх хүмүүс хэлж байна. ■



APPLICATIO
Training & Management

... Монголын төлөө таны чадавхи хөгжүүлэгч! ... Your competence developer for the Mongolia!

Менежментийн сургалт | Стратеги боловсруулалт

Management Training | Strategy Development

Чадавхийн сургалтууд | Цахим сургалт

Capacity Building | E-Learning

Өөрчлөлтийн менежмент | Төслийн менежмент

Change Management | Project Management

APPLICATIO Training & Management GmbH

Frauenthal 8, 20149 Hamburg / Germany

info@applicatio.com, P: +49-40-2208599, F: +49-40-2208646,

www.applicatio.com



ҮЗЭЛ БОДОЛ

ГЕРМАН-МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ БОЛОМЖ



ШТЕФАН ХАНСЕЛЬМАНН,
/ГОУХАН-ийн “Эрдэс баялаг, түүхий эд иж
бүрэн санаачилга хөтөлбөр”-ийн захирал/

Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн энэ оны гуравдугаар сард ХБНГУ-д хийсэн төрийн айлчлал Герман-Монголын бат бэх харилцааны баталгаа болсон билээ. Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам, Монгол улс хоёрын хоорондын техникийн хамтын ажиллагаа энэ онд 20 жилийн ойн баяраа тэмдэглэж байна. Түүнчлэн ХБНГУ-ын канцлер Ангела Меркель өнгөрсөн онд Монгол улсад айлчилж, түүхий эд, аж үйлдвэр, технологийн салбарт хамтарч ажиллах Засгийн газар хоорондын гэрээг үзэглэсэн нь хоёр орны түншлэл өргөжиж буйг илтгэх аж. Монголын байгалийн баялаг, Германы хамгийн сүүлийн үеийн технологи гэсэн бүтцийн өөрчлөлт нь хоёр үндэстний нэгнийгээ нөхөх суурь нөхцөлийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн хамтын ажиллагаа, герман компаниудын оролцоо нь хүлээлт болон боломжоос доогуур байгаа нь ажиглагддаг. Европын холбооны орнуудаас Герман нь Монголын хамгийн чухал худалдааны түнш юм. Манай хоёр орны худалдаа өнгөрсөн оны байдлаар 156 сая

евро байгаа нь дэлхийн хоёр дахь том экспортлогч орон болох Герман, байгалийн баялаг арвинтай Монгол улсын хувьд чамлалттай үзүүлэлт юм. Тодруулбал, Герман улс Монгол руу нийт 145 сая еврогийн өртөгтэй бараа бүтээгдэхүүн экспортолж, Монгол тус орноос 10.4 сая еврогийн бараа импортолжээ. Монгол улс Германы хувьд 122 дахь экспортын зах зээл нь байхад (2010), Германы импорт хийдэг орнуудын хувьд авч үзвэл 154

дэх нь Монгол (2010) билээ. Харин Монголын импортлогч орнуудын жагсаалтад Герман зургадугаар байр эзэлдэг. Германаас Монголын экспортолсон барааг сонирхуулахад, 2010 онд нийлүүлсэн хамгийн гол бүтээгдэхүүн нь машин механизм 34.2 хувиар, цахилгаан болон тээврийн хэрэгсэл 12.1 хувь, хүнс 9.5 хувь байна.

Хоёр талын эдийн засгийн харилцааг хөгжүүлэх суурь нөхцөл

Хэдийгээр Герман, Монгол хоёр улсыг хэдэн арван жил дотно, найрсаг харилцаа холбож байгаа ч Монголд үйл ажиллагаа явуулж байгаа герман компаниудын идэвх сул байна. Энэ нь олон шалтгаантай. Жишээлбэл, ▶



ХБНГУ-ын канцлер А.Меркель Монголд айлчилсан нь. 2011 оны аравдугаар сар



Монголын уул уурхайн компанийн төлөөлөгчид Германы ThyssenKrupp үйлдвэр дээр, Дюссельдорф 2012

► Герман улс жинхэнэ утгаараа уул уурхайн орон биш. Гэхдээ ирээдүйд герман компаниуд, хөрөнгө оруулагчид уул уурхайн төрөл бүрийн төсөлд хамтарч ажиллах бүхий л боломжийг сайтар судлах хэрэгтэй. Уул уурхайн төсөл, хөтөлбөрт оролцохын тулд заавал өөрөө энэ салбарын аж ахуйн нэгж байх албагүй. Германы талаас бие даасан компани, консорциумаар дамжуулж санхүүжилтийн асуудлыг шийдэх боломжийг хангалттай хэмжээнд авч үзээгүй байгаа (ялангуяа хувьцааны санхүүжилт).

Хоёр орны хамтын ажиллагаа олон жилийн түүхтэй, мөн Германд мэргэжилтэн мэдээлэлээр хангаж болох атал ихэнх тохиолдолд герман компаниуд Монголын тухай төдийлэн сайн мэддэггүй. Энэ нь Германы талаас мэдээлэл, өгөгдлийн зөв эсэхийг хангалттай хэмжээнд шалгалгүйгээр төсөл хөтөлбөр эхлүүлэхэд хүргэдэг. Ийм төсөл нь соёлын ялгаа, бэлтгэл тааруугийн улмаас урагшаа явдаггүй, эсхүл хэрэгжилтийн шатандаа амжилтгүй болдог. Улмаар германчуудын дунд Монголд төсөл хэрэгжүүлэхэд төдийлэн амжилттай болдоггүй гэсэн ташаа ойлголт байдаг нь харамсалтай. Учир нь Германы компанийнхан хуучинсаг үзэлтэй бөгөөд урт хугацааны, тогтвортой түншлэлийг зорьдог. Иймд

тэд өөрсдийн сонгосон төслийнхөө найдвартай түнш нь болж чаддаг. Нөгөө талаас Монголын хууль, засаг захиргааны нөхцөл байдал төдийлэн нээлттэй, урьдчилан таамаглах боломжгүй байдаг нь консерватив герман компаниудад тустай биш. Ихэнх тохиолдолд стратегийн томоохон төслүүдэд зохицуулалт тааруу байдаг. Монголын хууль тогтоомжийн том сул тал бол хууль батлахдаа үр дагаварт нь үнэлгээ хийдэггүй, хийсэн ч хангалтгүй байдаг талтай.

Хамтын ажиллагааны цаашдын хөгжлийн боломж

Герман, Монголын ирээдүйн хамтын ажиллагаа Германы ноу-хауг нэмүү өртгийн сүлжээ бий болгоход чиглүүлэх хэрэгтэй. Ингэснээр Монголд тогтвортой үнэ, ашиг болон бүтээмж нэмэгдэж, нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулна. Үүнд түүхий эд боловсруулах аж үйлдвэрийн салбарын нэг, хоёр жижиг төсөл дээр тогтож, урт хугацаанд хэрэгжүүлнэ. Энэхүү төсөлд тусгай нөхцөл байдал (татварын хөнгөлөлт, урт хугацааны гэрээ, баталгаа) үйлчлэхээр хийж болох аж. Эдгээр төсөл нь загвар байх тул төрийн зүгээс эрчимтэй хамтарч ажиллах хэрэгтэй (жишээ нь Монгол улсын Эдийн засгийн яамны хэлбэрээр).

Санхүүгийн түншлэл эсхүл төрийн байгууллагын эхний үед түр зуурын хамтын ажиллагаа байх боломжтой юм. Эдгээр төслийг дэс дараалалтай, сайн бэлдэх нь чухал. Энэ нь эхлээд хэдэн сая ам.долларын өртөгтэй судалгаа хийх хэрэгтэй гэсэн үг биш. Харин эхний ээлжинд гол асуудалд хариулт өгч, хөрөнгө оруулагчийн сонирхлыг татсан төслийн баримт бэлтгэвэл зохистой.

Сонгосон төслийг системчлэн боловсруулж, үүнийхээ дагуу Германтай харилцаа тогтооно. ГОУХАН-ийн “Эрдэс баялаг, түүхий эд иж бүрэн санаачилга” ЭТИС хөтөлбөрийн зүгээс эдгээр үйл ажиллагааг дэмжих эрхийг Германы талаас авсан. Хэрвээ төрийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх төсөл байгаа тохиолдолд Эдийн засгийн яаманд гурваас дөрвөн мэргэжилтэнтэй ажлын хэсэг зохион байгуулж, ЭТИС хөтөлбөртэй хамтарч ажиллах боломжтой.

Эдгээр төслүүд харин технологитой холбоотой, ирээдүйд чиглэсэн Монгол улсад урт хугацаанд үр ашгаа өгөхөөр байх ёстой. Германы эдийн засгийн хувьд төслүүд стратегийн ач холбогдол бүхий мөн л урт хугацаанд хэрэгжүүлнэ. Хамтрах герман түнш байгууллагаа сонгохдоо дунд хэмжээний аж ахуйн нэгжид хандах хэрэгтэй. Монгол улсад эдийн засгийн чадамж дээрээ суурилсан “German Mittelstand-sofensive” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой. Үүний зэрэгцээ мэдээж Нүүрс шингэрүүлэх үйлдвэр, Коксжуулсан нүүрс хэмээх томоохон төсөл мөн байх шаардлагатай гэж бодож байна. Энэ тохиолдолд ажлын байранд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр, ажлын байрны тоо доогуур байна. Германы эдийн засгийг зөвхөн томоохон үйлдвэрүүд болох “Siemens”, “Daimler”, “ThyssenKrupp” авч явдаггүйг хэлэх нь зүйтэй байх. Нийт герман ажиллагсдын 75 хувь нь жижиг, дунд үйлдвэрт ажилладаг. Германд дунд аж ахуйн нэгж нь 250 хүртэл ажилтантай, жилийн 50 сая еврогийн эргэлтийн хөрөнгөтэй байдгийг дурдъя. Германы эдийн засгийн хөгжлийн түлхүүр нь жижиг, дунд компаниуд юм. Тэдгээр нь дээд зэргийн уян хатан, инновацитай бөгөөд хэрэглэгчдээ хамгийн их ►

► үр ашиг санал болгодог. Тэдний дунд тухайн салбартаа технологи, туршлагаараа тэргүүлдэг олон “Нууц аваргууд” (“Hidden Champions”) байдаг. Монголын компаниуд эдгээртэй хамтарч ажиллах нь ихээхэн тохиромжтой гэж үзэж байна.

Герман улс уул уурхайн техник, нүүрс, коксжуулсан нүүрс, зэс болон бусад эрдэс баялгийг боловсруулахдаа дэлхийд тэргүүлэх ноу-хау ашигладаг. Эдгээр технологийг Монголд нэвтрүүлэхийн тулд Германы талын тусламжтайгаар орчин үеийн олон улсын норм норматив, стандартад нийцсэн тогтолцоог боловсруулах хэрэгтэй гэж үзэж байна. Энэхүү стандартыг хэрэгжүүлээгүй тохиолдолд өрсөлдөөн зөвхөн үнээр тодорхойлогдоно. Тухайн бүтээгдэхүүний чанар болон баталгаа нь Хятадаас орж ирсэн хямд импортын бараанд дарагдана. Үүнээс гадна өнөөгийн байдлаар сул байгаа Монголын стандартын тогтолцоо нь Австрали, Канад, Герман, Япон зэрэг

улсаас стандарт оруулж ирэхэд улам асуудалтай болно. Монгол улс энэ тал дээр ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулахаар харагдаж байгаа. Техникийн дүрэм журам, стандарт нь эдийн засгийн хөгжлийн зайлшгүй тавигдах ёстой суурь учраас ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөр тус сэдвийг олон жил дэмжсээр ирсэн. Орчин үеийн норм, стандартын тогтолцоо нь зөвхөн томоохон техникийн төслүүд дээр биш, түүнээс гадна Монгол улсын шинэчлэлд мөн хувь нэмрээ оруулах юм. Жишээлбэл, ажлын байрны хамгаалал, баталгаанд ч гэсэн олон норм, стандартыг баримталдаг.

Уул уурхайн төслийн тоо зах зээлд олшироход цаг хугацаа шаардана. Оюутолгой, Тавантолгой гэсэн томоохон төслүүдийг оруулсан ч хэрэгжилтийн шатандаа явж байгаа уул уурхайн бизнес харьцангуй жижиг. Германы ханган нийлүүлэгчдийн хувьд Канад юм уу Австралийн уул уурхайн төсөлтэй хамтрахад бэрхшээлтэй. Яагаад гэвэл “Рио Тинто” гэхчлэн

компаниуд үйлчлүүлэгчийнхээ техникийн асуудлыг олон жилийн турш хариуцсан. Өсөн нэмэгдэж байгаа уул уурхайн төслүүд харин Германы уул уурхайн ханган нийлүүлэгчидтэй хамтрах суурийг бий болгох бөгөөд үйл ажиллагааны чиглэлээр төрөлжин Монголд байрлах болно (Жишээлбэл, Германы тэргүүн туршлага төв дэх “Voith” компани). Энэ нь ажлын байр, технологийн ноу-хауг бий болгоно.

Герман, Монгол хоёр орон эдийн засаг, технологийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй байдгаа олонтаа илэрхийлсэн. Монголд өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц хурдацтай явагддаг, мөн эрдэс баялийн арвин нөөцөөрөө дэлхийн олон орны сонирхлын төвд буйг Герман болон тус улсын бизнесийнхэн бусдын адил анхааралтай харж байх ёстой. Нөгөө талаас Монгол гуравдагч түнш орны бодлого хийгээд Герман улстай хамтрах эдийн засгийн хамтын ажиллагааг тодорхой болгох шаардлагатай байна. ■

KHATAN TUUL
Pure Water

Packaging quantity of Pure water:

0.35 L /bottled/	Маркетинг: 99071655
0.6 L /bottled/	Захиалга авах утас: 70173386
1 L /bottled/	Факс: 976-11-70174494
19 L /ballon/	

Produced and bottled by "Welmon Trade" Co., Ltd of Mongolia

ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

ХЭМНЭЖ, ГАМНАХ УХААН

Э.ЛУТАА

...Хэмнэлт хийхийн тулд хийсэн хөрөнгө оруулалтын зардлыг ирээдүйд хэмнэлтээс үүсэх ашгаар нөхдөг гэдгийг талууд сайтар ойлгох хэрэгтэй...

Эрчим хүчтэй холбоотой гардаг үй түмэн зардлыг багасгах сонирхол хүн төрөлхтний өмнө тулгараад эдүгээ 60 гаруй жилийн нүүр үзээд байгаа аж. Энэ шаардлагын үүднээс эрчим хүчний хэмнэлтийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд ч байгуулагдаж эхэлжээ. Эрчим хүчний хэмнэлтийн анхны компани 50 гаруй жилийн өмнө Францад байгуулагдаж улмаар, 1960-аад оны дунд үеэс Америк, Канадад дэлгэрсэн байна. Харин сүүлийн жилүүдэд Хятадад эрчим хүчний хэмнэлтийн компаниуд нэлээд амжилттай үйл ажиллагаагаа явуулж эхлээд байгаа аж. Улс бүрт эрчим хүчний хэмнэлтийн компаниуд үйл ажиллагаагаа янз бүрээр нэрлэдэг. Тухайлбал, АНУ-д “Хэмнэлтийн гэрээ ба гүйцэтгэл” гэдэг бол Европын орнуудад “Технологийн гэрээний гүйцэтгэл”, Англид “Гуравдагч талын санхүүжилт” гэх мэтчилэн нэрлэдэг ажээ. Харин манайд өдгөө энэ төрлийн компанийн нэр нь битгий хэл бараа нь ч алга.

Тэд ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?

Эрчим хүчний хэмнэлтийн компаниудын гол зорилго бол

үйлчлүүлэгчийнхээ эрчим хүчний менежментэд өөрчлөлт хийж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх. Мөн тухайн компанийн хэрэгцээнд тохируулан эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэхэд шаардлагатай техник, санхүү, хяналт шалгалт, засвар үйлчилгээ гээд бүх төрлийн үйлчилгээг үзүүлдэг байна. Гэхдээ зарим тохиолдолд эдгээр компани үүргээ нэр төртэй биелүүлж чадахгүйд хүрдэг аж. Тэр дундаа Монгол шиг эрчим хүчний хэмнэлтийн талаарх ойлголт маруухан, энэ төрлийн компанийн талаар сураг төдий мэддэг зах зээлд оршин тогтнох нь тэдний хувьд асуудалтай байдаг гэнэ.

Эхний асуудал

Дэлхийн эдийн засаг өнөөдөр үйлдвэрлэл, хэрэглээ хоёр дээр л “тэнхлэгээ эргэж” байна. Гэхдээ үйлдвэрлэгчид ч гэсэн хэрэглэдэг. Тэр нь эрчим хүч. Эрчим хүчгүй бол өндөр технологийн энэ зуунд хэн ч юу ч үйлдвэрлэж чадахгүйд хүрнэ. Тиймээс үйлдвэрлэгч тал нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эрчим хүчний зардлыг багасгах тал дээр ихээхэн анхаардаг. Энэ нь хямд зардлаар илүү чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх тэмүүллийн нэг хэлбэр юм. Харин Монгол улс сүүлийн 20 гаруй жил эрчим хүчний салбартаа салхи оруулаагүй, үнэ нь төрөөс хараат байгаа энэ үед үйлдвэрлэгчид эрчим хүчний хэмнэлтийн талаар санаагаа чилээхгүй байгаа нь аргагүй юм. Учир нь нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зардалд эрчим хүчний үнийн эзлэх хувь бага байгаа хэрэг. Тиймээс эрчим хүчний үнийг чөлөөлөх нь зарим талаар хэмнэж,

гамнах ухагдахууныг хэрэглэгчдийн тархинд суулгах арга байж болох юм. CO-Firm, Hamburg and McKinsey and Co зэрэг компаниудын зөвлөх Даниел Хессе “Эрчим хүчний хэмнэлт болон зах зээл түүнд тулгуурласан хэрэгслүүдээр дамжуулж эдийн засгийн хувьд ихээхэн хэмнэлт бий болгодог нь олон улсын туршлагаас харагдана. Тухайлбал, эрчим хүчний хэмнэлтийн үйлчилгээ үзүүлдэг компани өөрийн ноу-хау болон санхүүгийн эх үүсвэрээр дамжуулан эрчим хүчний хэрэглээг багасгах, бодит хэмнэлт үүсгэх нөхцөлийг найдвартай хангах учиртай” гэсэн юм.

Манай улс зах зээлийн эдийн засагтай. Гэтэл эрчим хүчний салбарт эдийн засгийн үр ашгаас илүүтэй найдвартай үйл ажиллагааг чухалчилдаг. Гэхдээ үйлдвэрлэл явуулж буй учраас алдагдлаа нөхөх зүй ёсны шаардлага нэхэх нь зах зээлийн хууль. Тиймээс эрчим хүчний салбарын үнийг чөлөөлж, зах зээлийн зөв хэмнэлд оруулахгүй л бол хөрөнгө оруулалт буурч байгааг салбарынхан хэлдэг. Хөрөнгө оруулалт буурсантай холбоотой тухайн салбарт засвар шинэчлэл цаг тухайд нь хийгддэггүй. Үүнтэй холбоотой салбарын аюулгүй ажиллагаа ч мөн алдагддаг. Тиймээс өдгөө эрчим хүчний салбарын толгойны өвчин болж буй гол асуудал бол өндөр насжилттай эрчим хүчний тоног төхөөрөмжөө шинэчлэх болоод байгаа. Дээрээс нь Манай улсын эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 8-10 хувийн өсөлттэй байгаа нь эрчим хүчний дутагдалд орох шалтгаан болж буйг Эрчим хүчний яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Товуудорж хэлсэн ▶

► юм. Тиймээс эрчим хүчний үнийг аль болох зах зээлийн жамаар, гэхдээ иргэдэд хүндрэл учруулахгүйгээр нэмэх нь чухал байна. Түүнчлэн үнийг чөлөөлснөөр манай эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, үүрэг оролцоог нэмэгдүүлэх нөгөө талаар хүн бүрийн тархинд хэмнэх гамнах ойлголтыг суулгаж өгөх учиртай. Эрчим хүчээ хэмнэх нь наад зах нь байгаль орчинд ээлтэй. Тухайлбал, нүүрстөрөгчөөс аваад хүний эрүүл мэндэд хортой 200 гаруй химийн хорт бодис агуулдаг утааны өчүүхэн хэсгийг ч болов багасгах юм.

Дараагийн асуудал

Эрчим хүчний хэмнэлт гаргахын тулд юуны түрүүнд техникийн шинэчлэл хийх шаардлагатай байдаг аж. Мэдээж олон улсын стандартад нийцсэн өндөр чанартай технологи оруулж ирэх нь ямар ч компанийн хувьд санхүүгийн дарамт дагуулдаг байна. Энэ дарамтаас ихэнх нь айдаг бөгөөд техникийн шинэчлэл нь богино хугацааны санхүүгийн тооцоогоор тодорхой хэмжээний алдагдлыг үйлдвэрлэгч талд авчирдаг аж. Урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөгүй байгууллагууд эрчим хүчний хэмнэлтийн талаар анхаарахгүй байх нь элбэг байдаг гэнэ. Тиймээс энэ үзэл бодлыг өөрчлөх, урт хугацаанд ирэх ашгийн талаарх тооцоог хийх мэргэжлийн байгууллага зайлшгүй шаардлагатай байдаг аж. Энэ нь эрчим хүчний хэмнэлтийн компани юм. Тэд үйлдвэрлэгч талд нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагдаж байгаа эрчим хүчний зардал. Хэмнэлт хийх боломж, хийснээр ирээдүйд ирэх ашиг зэрэг бүх зүйлийг тооцож өгдөг байна. Даниел Хессе “Хэмнэлт хийхийн тулд хийсэн хөрөнгө оруулалтын зардлыг ирээдүйд хэмнэлтээс үүсэх ашгаар нөхдөг гэдгийг талууд сайтар ойлгох хэрэгтэй” гэсэн юм. Тухайлбал, Германы ВЕА байгууллага энэ төрлийн төслийг Берлин хотын 1400 орчим байгууллагад хэрэгжүүлсэн бөгөөд нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг жилд дунджаар 68 000

1128 мВт

2020 ОНД ОРГИЛ
АЧААЛАЛ 1128 МВТ-Д
ХҮРЭХ ТӨЛӨВТЭЙ ГЭНЭ.



t/a нэгжээр бууруулсан байна. Мөн хөрөнгө оруулалтын ашгийг тооцож үзэхэд тухайн байгууллагууд эрчим хүчний төслийг бүрэн хэрэгжүүлж эхэлсэн жилийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад дунджаар 11.3 сая евро буюу нийт эрчим хүчний зардлын 26 хувьтай тэнцэх хэмжээний хэмнэлт бий болгож чадсан гэсэн дүн гарчээ.

Хэлсэндээ хүрэхгүй бол яах вэ

Эрчим хүчний хэмнэлтийн компани танай байгууллагатай

хамтран ажиллаж, тодорхой амлалт өгчихөөд биелүүлэхгүй бол яах вэ. Энэ тохиолдолд хамгийн их хохирол хүлээх тал бол мэдээж үйлдвэрлэгч юм. Тиймээс талууд үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө гэрээний нөхцөлүүдээ сайтар тохиролцох хэрэгтэй аж. Тухайлбал, Европд үйлдвэрлэгч талаас эрчим хүчний хэмнэлтийн компанид тавих шаардлага нь нэлээд өндөр байдаг гэнэ. Festo Didactic GmbH and Co.KG-д Ойрхи Дорнод, Ази Номхон далайн бүсийн менежер Гүэнтэр Хаин “Хэрэглэгчийн шаардлага, тоног төхөөрөмж нийлүүлэгчийн санал нийцэж байж л эрчим хүчний үр ашигтай ашиглалт бий болгож чадна. Тиймээс талууд өөрсдийн хүлээх хариуцлага, шаардлага зэргийг үйл ажиллагааны гэрээндээ сайтар тусгаж өгөх хэрэгтэй. Харин хэлсэндээ хүрэхгүй бол тухайн гэрээнийхээ дагуу хариуцлага хүлээнэ. Мөн үр ашигтай ажиллахын тулд ашиглах технолого сайтар судлах хэрэгтэй. Учир нь технологи бүр өөр өөрийн гэсэн давуу талтай ч бас сул талтай. Тиймээс өөрт тохирсон технологийг өндөр үр чадварын дагуу ашиглах зарчим юм” гэв.

Улаанбаатарт жил ирэх тусам өндөр гоёмсог орон сууц, албан байгууллагын барилга болон бусад үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжсөөр байгаа нь сайхан ч нөгөө талд цахилгаан, дулааны хомсдол нүүрлэх вий гэсэн айдас хаа сайгүй. Ганцхан жишээ дурдахад, манай эрчим хүчний системийн оргил ачаалал 2010 онд 728 мВт-д хүрэхэд дулааны цахилгаан станцууд бүрэн хүчин чадлаараа ажиллаад ч дийлэхгүй байсан тул хойд хөршөөс 70 мВт эрчим хүч нэмж импортлосон. Харин 2020 онд оргил ачаалал 1128 мВт-д хүрэх төлөвтэй гэнэ. Энэ хугацаанд ТЭЦ-V ашиглалтад орох хэдий ч хурдтай өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй юм байна. Тэгвэл яах вэ. Хамгийн энгийн хариулт нь эрчим хүчний замбараагүй хэрэглээгээ багасгах юм. Тухайлбал, Монгол улсын 2.7 сая иргэн гэр гэртээ эрчим хүчний хэмнэлт хийж чадвал эдийн засгийн багагүй үр ашиг авчрах аж. ■

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

КОМПАНИ+ТӨР+ИРГЭН= ХАРИУЦЛАГА

Х.ХУЛАН

...Компанийн нийгмийн хариуцлага зөвхөн уул уурхай бус, бизнесийн бүхий л салбарт хамааралтай. КНХ-ын асуудал Монгол улсад хөгжих үйл хэдийнэ өрнөсөн бөгөөд даяаршсан ертөнцөд ухрах зам байхгүй...

Хүн төрөлхтний туулж өнгөрүүлсэн түүхийг сөхөж үзвээс, аж үйлдвэржилтийн эрин үеийг онцлохгүй байх аргагүй. Тэртээх 1800-гаад онд Европт хөгжиж эхэлсэн аж үйлдвэржилтийн хувьсгал нь техник, технологийн дэвшлийг дагуулсан. Үүний зэрэгцээ магнат пүүс, компаниуд байр сууриа эзэлж, хөдөө орон нутгаас сайхан амьдрал мөрөөдсөн олон хүн хот, суурин газрыг бараадах болсон. Аж үйлдвэржилт хөгжин цэцэглэж, хотжилтийн хөдөлгөөн улам бүр газар авсан нь нийгэмд ангийн ялгаа гарахад нөлөөлсөн. Нийгмийн дундаж давхарга бүрэлдэн тогтохын сацуу чинээлэг болон ажилчин анги ч зэрэгцэн оршин тогтнох болсон. Анхны унадаг дугуй, дуу хураагч, бичгийн машин, автомашин зэрэг цоо шинэ бүтээгдэхүүн зах зээлийг хачирлах болов. Ийнхүү аж үйлдвэр, худалдааны ашиг орлого өдрөөс өдөрт нэмэгдэхийн сацуу саар зүйл ч ихээхэн байлаа. Тэр нь юу вэ гэвэл,



хүн байгалийн хүйн холбоо холдсон явдал юм. Үйлдвэрүүд агаар, ус, газар дэлхийг асар их хэмжээний хортой бодис, хаягдлаар бохирдуулдаг байв.

Яагаад хариуцлага?

Өнөөгийн корпорацийн суурийг тавьсан аж үйлдвэржилтийн эрин үе байгаль орчинд төдийлэн ээлтэй байсангүй. Өөрөөр хэлбэл, зөвхөн ашгийн төлөө л ажиллацгааж байж. Компанийн нийгмийн хариуцлагын тухай сүүлийн үед дэлхий даяар ярих боллоо. Гэтэл энэ нь аж үйлдвэр эрхлэгчдийн хувьд цоо шинээр гарч ирсэн нэр томъёо биш билээ. Нөгөө л аж үйлдвэржилтийн эхэн үед томоохон компани, корпорациуд ажилчдынхаа ажиллах орчин, нийгмийн асуудалд анхаардаг байж.

Өнгөрсөн зууны 50-иад онд Америкт “Бизнес эрхлэгчийн нийгмийн хариуцлага” (Social responsibility of the businessman) хэмээх ойлголт гарч ирснийг Европын олон улс хэрэгжүүлж эхэлсэн. Томоохон компаниуд өөрийн үйлчлүүлэгч, ажиллагсад, нийгмийн өмнө хариуцлага хүлээх ёстойг ухамсарласан. Мөн 1980-аад онд экологийн хариуцлагын сэдвийг нэмж хөндөх болсон. Энэ нь юуны өмнө байгаль орчны асуудал дэлхийн хэмжээнд өөрчлөгдсөнтэй уялдаатай аж. Рио де Жанейро хотод 1992 онд чуулсан Дэлхийн дээд хэмжээний уулзалтаар улс төрийн эрх баригчид, улс орны тогтвортой байдалд эдийн засгийн салбар зайлшгүй орно гэж санал нэгдсэн юм. Харин эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгохдоо байгаль орчны тогтолцоог ▶

▶ хангаж байж тогтвортой хөгжинэ гэдгийг анх удаа гаргаж ирсэн юм.

Компанийн нийгмийн хариуцлагын үндэсний форум

Компанийн нийгмийн хариуцлага нь Монгол улсын хувьд шинэ сэдэв биш. Харин энэ асуудал нь дараагийн шатандаа явж байна гэж өнгөрсөн сарын 24-нд “Blue Sky” цамхагт болсон “Компанийн нийгмийн хариуцлагын үндэсний форум”-ын үеэр Санхүүгийн зохицуулах хорооны

талуудын үүргийг улам тодорхой болгоход тус дэмтэй байлаа.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун илтгэлдээ КХН нь чухал асуудал бөгөөд техник технологи, байгаль орчны стандартыг өндөрсгөх хэрэгтэйг тэмдэглэв. Түүнчлэн тэрбээр орон нутаг, иргэний нийгмийн оролцоотой ногоон өсөлтийг бий болгох хэрэгтэй байгааг чухалчлан хэллээ. Дашрамд дурдахад, тогтвортой хөгжлийн асуудлыг шинэ Засгийн газраас онцлон авч үзэж буй бөгөөд Тогтвортой хөгжлийн хороо байгуулсан байна. Тус хороог Ерөнхий сайд Н.Алтанхуяг даргалах

тайлан гэдэг нь тухайн компаниас тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр, амжилт ололтоо олон нийтэд тайлагнахыг хэлнэ” гэж илтгэлдээ тайлбарлав. Ихэнх улс тайлангаа сайн дурын үндсэн дээр гаргадаг аж. Сонирхуулахад, Франц (анх 2001 оноос), Шведэд (2008 оноос хойш) КНХ-ын тайланг компаниуд заавал гаргадаг болжээ. Бас нэг жишээ дурдахад, манай урд хөршид энэ сэдвийг сүүлийн үед түлхүү ярьж, эрчимтэй хөгжүүлж байгаагийн илрэл нь тайлангаа байнга гаргадаг болсон явдал юм. Анх 32 байсан КНХ-ын тайлан Хятадад өнөөдөр 890-д хүрсэн байна гэж Рольф Дийтмар ярилаа.

Хувийн хэвшил, төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл чуулга уулзалтад оролцож, санал бодлоо солилцлоо. МҮХАҮТ-ын Нэгдсэн бодлого, төлөвлөлт зохицуулалтын дарга Ч.Нэргүй Монголын компаниуд нийгмийн хариуцлагын тайлангаа гаргадаггүй, энэ тал дээр анхаарах хэрэгтэй хэмээн сануулсан. Мөн МАОЭХ-ны дэд дарга Х.Ганбаатар олон улсын стандарт ISO 26000-ыг мөрдүүлж, КНХ-ыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн оролцоо чухал гэдгийг тэмдэглэв.

Монгол улсын эдийн засгийн өсөлтөд жин дардаг уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагыг үндэсний хэмжээнд өнөөдөр гол асуудал болгож үзэх шаардлагатай байгаа. Учир нь байгалийн баялгаа зөвхөн ашиглах биш, байгаль орчинд ээлтэй технологи ашиглаж, орон нутагт уул уурхайн үйл ажиллагааны талаар зөв ойлголт өгөх хэрэгцээ байна. Ер нь КНХ зөвхөн уул уурхай бус, бизнесийн бүхий л салбарт хамааралтай билээ.

Энэхүү форумар төр, компани, иргэний нийгэм хамтарч нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлбээс илүү үр дүнд хүрнэ гэсэн дүгнэлт гарлаа. КНХ-ын асуудал Монгол улсад хөгжих үйл хэдийнэ өрсөсөн бөгөөд даяаршсан ертөнцөд ухрах зам байхгүй. Эцэст нь хэлэхэд, яагаад компаниуд хариуцлагатай байх ёстой гэж Та бодож байна вэ. Сүйтгэгдсэн байгаль орчин, өвчинд нэрвэгдсэн нийгэмд бизнес оршин тогтнох уу? Хариуцлагатай хөгжил өөд, урагшаа! ■

дэд дарга Г.Хэрлэн хэллээ. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн санаачилга” хөтөлбөрөөс санаачилсан эл арга хэмжээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, ХБНГУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд Петер Шаллер нар нээж үг хэллээ.

Форумын үеэр КНХ дэлхийд өнөөг хүртэл хэрхэн хэрэгжиж ирсэн хөгжлийн үе шат, олон улсын стандарт ISO 26000 болон КНХ-ын тайлангийн ач холбогдол, Монгол улсад КНХ-ыг салбараар хөгжүүлэхэд ямар үйл ажиллагаа явуулбал зохистой тухай танилцууллаа. Түүнчлэн нийгмийн хариуцлагыг дэлгэрүүлэх үйлсэд төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд ямар оролцоотой байх талаар ч хэлэлцсэн нь оролцогч

бөгөөд эдийн засгийн өсөлтийг байгаль орчин, нийгмийн асуудалтай цогцоор нь хөгжүүлэх тал дээр анхаарах аж.

КНХ бүх түвшний компанид хамааралтай ойлголт бөгөөд уул уурхай, барилга, нийтийн тээвэр, аялал жуулчлал, боловсруулах аж үйлдвэр гэхчлэн салбар бүрт нэвтрүүлэх шаардлагатай байгаа тухай Эдийн засгийн хөгжлийн яамны Салбарын хөгжлийн бодлогын зохицуулалтын хэлтсийн дарга Д.Эрдэнэбаяр хэлэв.

Форумаар авч хэлэлцсэн өөр нэг гол асуудал бол компаниуд нийгмийн хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлж байгаагаа нийтэд тайлагнадаг тайлангийн асуудал байлаа. ГОУХАН-ийн Хятад дахь КНХ-ын төслийн удирдагч Рольф Дийтмар “КНХ-ын



ХҮНИЙ ХӨГЖИЛ

“ХҮНИЙ ХӨГЖИЛ ОРХИГДОХ ЁСГҮЙ”

Х.АНАНД

...Би мөрөөдөгч биш. Дэлхийн хэмжээнд хүрч, олон хүнд үйлчлэхийн тулд бүтцийн хувьд том, олуулаа байх шаардлагагүй гэж боддог. Харин тухайн хүмүүст өгч байгаа мэдээлэл, заах арга, агуулга маань л өргөн цар хүрээтэй, дэлхийн хэмжээнд байх ёстой...

Герман-Монголын бизнесийн өдрүүд чуулга уулзалтын үеэр мэргэжлийн боловсролын сургалт, хүний нөөцтэй холбоотой асуудлууд багагүй дурдагдсан. Энэ чиглэлээр хоёр, гурван ч салбар хуралдаан болж, германчууд туршлагаасаа хуваалцсан. Харин бидэнд эхнэртэйгээ хамт манай редакцийг зорьж ирсэн “Апликацио” компанийн захирал Торстен Тредегийн яриа сонирхолтой байв. Түүний яриа мөн л хүний нөөц, мэргэжлийн боловсролтой холбоотой байсан юм. Хамгийн гол нь Монголд 1994 оноос ажилласан тэрбээр хийсэн ажил, хэлэх үгтэй нь бахархал төрүүлэх. Хувь хүн болоод байгууллагын хөгжилд тустай сургалт, зөвлөгөө явуулдаг нь Монголд ч үр дүнгээ өгчээ. Торстен “Миний танай сэтгүүлд өгч байгаа мэдээлэл манай компанийн сурталчилгаа гэхээсээ илүүтэй уншсан хүнд нэгийг бодож, хоёрыг хийх сэдэл өгвөл зорилго биеллээ гэсэн үг” хэмээн тэмдэглэсэн юм.

Хүний нөөц, чадавч болон зайны сургалтын чиглэлээр мэргэжлийн зөвлөхийн үйл ажиллагаа явуулдаг

“Applicatio training and management” компани нь албан ёсны зургаа, гэрээт 30 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. 1993 онд байгуулагдсан тус компани Төв Ази, Зүүн Европ, Африкийн өмнөд хэсгийн зарим оронд урт болон богино, дунд хугацааны 400 гаруй төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд байгаа бөгөөд зөвхөн Монголд 60 гаруй төсөл амжилттай хэрэгжүүлж, үр дүнгээр нь бахархан ярьж байна. Торстен “Монголын эдийн засгийн галт тэрэг хурдаа улам бүр нэмж, түүнд дайгдсан олон зуун хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт болж хувирч байна. Энэ хурд хүнд оруулах хөрөнгө оруулалтыг орхиж болохгүй” гэсэн юм.

Тэрбээр хүний чадамж, сэтгэн бодох хийгээд, хийж байгаа ажилдаа ур чадвартай төдийгүй түүнийхээ эзэн болж, бусдаас чадварын хувьд хараат бус байхад бусдыг сургах, зөвлөгөө өгөх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг. Үүний төлөө тус компанийн зөвлөхүүд орон орныг зорьдог байна. Тэд “Бодлогын түвшний хөгжил” буюу

удирдан зохион байгуулагчдын арга барил, ажилчдаа урамшуулах, ажиллуулахад юу хэрэгтэй болон удирдагч хүн хэрхэн өсөн дэвжиж, өөрийгөө хөгжүүлэх тухай сургалтыг мэргэжлийн түвшинд, бүх шатанд зааж, зөвлөж, сургадаг байна. Түүнчлэн зөвлөх үйлчилгээний салбар буюу тухайн байгууллага хамт олны хүссэн хүний нөөц хийгээд хэрхэн эдийн засгийн дэмжлэг авах чиглэлээр хэрхэн дэмжүүлэх, дэмжих, өсөн нэмэгдүүлэх зэрэгт зөвлөгөө өгдөг. Гуравдугаарт, цахим буюу зайны сургалтаар бүх салбарт зөвлөж, сургалт зохион байгуулдаг аж.

Эдийн засгийн дэмжлэг авах болон хэрхэн дэмжих талаарх сургалтын тухай тодруулахад “Тухайн жижиг, дунд үйлдвэрлэгч, эсвэл компани, байгууллагад эдийн засгийн хувьд хэрхэн ажиллавал биеэ даах хийгээд цаашид хөл дээрээ бат зогсож чадахыг зөвлөхийн зэрэгцээ тус салбарт хөрөнгө оруулагчдад зөвлөгөө өгдөг. Үүний ач тус нь тухайн хөрөнгө оруулагч хамтран ажиллах жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид итгэх, цаашид ашиг, орлого олох боломж байгаа хийгээд хэрхэн дэмжвэл хамтран илүүг олж болох гарцаа тодорхойлоход нь тусалдаг зэрэг давуу талтай. Энэ нь хөрөнгө оруулахаас айж, мөнгөө хав дарж буй хүмүүст ихээхэн тус нэмэр болдог гэж бодож байна хэмээн Торстен ярьсан юм. ▶

400

НЭГ УДААГИЙН ТӨСЛИЙН
ҮР ДҮНД АЖЛЫН
БАЙРААР ХАНГАГДСАН
ХҮНИЙ ТОО

► Төсөл бүхэн амжилттай хэрэгждэг

Монголд хэрэгжүүлсэн төслүүд үр дүнгээ өгч, сургалтад хамрагдсан хүмүүсийн 90 гаруй хувь нь зөвлөхийн чиглэлээр болон тухайн салбартаа түүчээ нь болж явааг тэрбээр “Бидний хэрэгжүүлсэн төслийн үр дүнд зөвлөхийн тоо вирус адил тархаж, ажил, амьдрал нь сайжирсаныг харах сайхан байдаг” гэж дүгнэсэн юм. Тухайлбал, GIZ олон улсын байгууллагын захиалгаар Дархан-Уул, Орхон, Завхан гэсэн гурван аймагт шинээр бизнес үзсэн байгуулагчдыг төлөвлөгөө бичих, төлөвлөхөд нь сургах төсөл хэрэгжүүлсэн байна. Төсөлд хамрагдсан хүмүүс маш амжилттай суралцаж, зөвхөн энэ төслийн хүрээнд зөвлөх болон бусад үйлчилгээ эрхлэх 80 гаруй байгууллага үүсэж, 400 гаруй хүнийг ажлын байраар хангаж, 30 гаруй зөвлөх өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ бол Монголоос дурдах дуртай хамгийн сайн үр дүн. Мөн 2006 онд гурван хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхэлж байсан “Цахим мэдлэг” байгууллагыг амжилттай ажиллахад нь туслах зорилгоор зайны сургалтад хамруулж, хамтран ажилласнаар өдгөө 150 гаруй төгсөгчтэй ТББ болон өргөжсөн байна. Тус ТББ



“Апликацио”-гийн сургалт

өнөөдөр Монголд үйл ажиллагаа явуулж буй бүх их, дээд сургууль болоод бусад сургалтын байгууллагад зайны сургалт зохион байгуулж, бусдад зөвлөх үйл ажиллагаа хийсээр байгаа юм. Түүнчлэн удирдлага зах зээлийн менежер бэлтгэх зорилгоор Монголд урт хугацааны хөтөлбөр есөн удаа хэрэгжүүлээд байгаа аж. Хөтөлбөр тус бүрт дунд түвшний 15-20 залуу болон дээд түвшний менежерүүдийг ХБНГУ-д жил гаруй хугацаагаар бэлтгэн мэргэжлийн сургалтад хамруулсан байна. Төсөлд хамрагдсан 180 гаруй мэргэжилтний ихэнх нь Монголд хувийн зөвлөх үйлчилгээний компани байгуулж, бизнесийн салбар төдийгүй улс төр, бодлого тодорхойлогчид болсон нь тус байгууллагын бас нэгэн бахархал аж.

“Апликацио” компани голлон GIZ, Дэлхийн банк, Европын холбоо, UNDF зэрэг дэлхийн томоохон сан, хувийн хэвшлийн цөөнгүй байгууллагатай хамтарч ажилладаг. Үүнээс гадна тус байгууллага нийгмийн болоод байгаль орчны чиглэлээр цөөнгүй зүйл санаачилж, ажил хэрэг болгоод байна. Тухайлбал, ядуурал, байгаль орчны доройтол, цөлжилт, хүүхэд, залуусын спортоор дамжуулан эрүүл байх үндсийг хангах зорилгоор цөөнгүй төсөлд нэгдэж, ивээн тэтгэгчээр ажиллаж байна. Байгальд ээлтэй аяллын удирдлага нэвтрүүлж, санаачилсан учраас “Апликацио” компани Олон улсын CSR-Mobility Award шагналын эзэн, 2010 оны шилдэг компани зэрэг дэлхийн хэмжээний олон шагнал хүртэж байжээ. ►►



67 ДАХЬ УДААГИЙН “АЙЛЧЛАЛ”

► Торстен ХБНГУ-ын Хамбург хотод төрж өссөн герман хүн. Гэхдээ түүний амьдралын хэвшил хийгээд зарим хобби нь монгол зан заншил, өв соёлыг ханхлуулж байдгийг түүний гэргий Гэрэлчимэг ярьсан. Торстен Монголд 67 дахь удаагаа ирж байгаа бөгөөд түүний энэ удаагийн “зочлол”-ын талаар цөөн хором ярилцлаа.

-1993 онд Монголд ирж байсан сэтгэгдэл, энэ удаад онгоцноос буусан хоёрын хооронд их ялгаа байна уу. Монгол таныг анх ирж байх үеэс хэр өөрчлөгдсөн байна вэ?

-1993 он, 2012 оны Монголыг харьцуулашгүй өөрчлөгдсөн гэж хэлж чадна. Учир нь намайг энд ирж байх үед эдийн засаг хийгээд нийгмийн амьдралын шилжилтийн хүнд үе тохиож байсан. Харин одоо бол гадаадын хөрөнгө оруулагчид Монголыг л сонирхож, үүнийг дагасан хөрөнгө оруулалт минут, секундээр хэмжигдэж, хүн ардынх нь амьдрал ч нэлээд сайжирсан. Үнэнийг хэлэхэд анх онгоцноос буучихаад хурдхан буцчихмаар санагдаж байсан. Харин одоо бол тийм биш. Монголд ирэх нь заримдаа амралт юм шиг санагддаг.

-Ази, Африк, Латин Америкийн гээд олон оронд ажиллаж байжээ. Таны ажиллаж байсан орнуудын нийгмийн амьдрал, хүний хөгжлийн хувьд ялгаа хэр байдгийг сонирхохгүй өнгөрч болохгүй нь.

-Энэ онд л гэхэд би дэлхийн 12 оронд очиж, ажилласан байна. Эхэндээ бол хүмүүсийн амьдралын зан заншил, соёл, биеэ авч яваа байдал гэх зэргийг их сонирхож, хооронд нь харьцуулж дүгнэдэг байсан. Харин одоо бол бараг тэгэхээ больсон. Гэхдээ монголчууд бусад орны ард түмнийг бодоход тайван “За яахав болно доо” гэсэн байдлаар юманд ханддаг. Харин бусад нь бол юманд их яардаг, хариуцлагатай

байхыг хичээдэг. Миний ажилладаг гол бүс болох Төв Ази, Зүүн европ, Африкийн орнуудын ард түмэнд адил төстэй зүйл олон ч нэг зүйл бүр дэндүү төстэй байна. Бүгд шинэ зүйлийг сурч мэдэхийг хичээдэг, сурахдаа биеэ дайчлах, тэмүүлэх хүсэл сонирхол, хүлээж авах байдал нь төстэй. Энэ нь магадгүй бидний ажилд олз болдог. Учир нь сурах, ажиллах, хөдөлмөрлөх, амьдралын төлөө зүтгэх зорилготой хүмүүс аливааг хамгийн сайн сурч, цаашид мөрддөг.

-“Монгол-Германы бизнесийн өдрүүд” чуулганд ирсэн зорилгоо биелүүлж чадсан уу. Мэдээж шинэ хамтрагч, түнштэй болохоор ирсэн байх.

-Манайх дэлхийн олон улсын хөгжлийн байгууллагуудтай голлон хамтарч ажилладаг. Тэдний захиалгаар тухайн бүс нутгийнх нь хөгжлийн байгууллагатай хамтран зөвлөгөө, тусламж хэрэгтэй бүс нутагт очиж ажилладаг. Чуулганд оролцох зорилгоо маань мэдээж шинэ түнш олох, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагын туршлагаас хуваалцах байсан. Бид зорилгоо биелүүлсэн гэж бодож байгаа. Учир нь Монголд зөвлөх үйлчилгээний учрыг ойлгодог, хүлээж авдаг болсон байна. Энэ бол бидний өмнө нь хийсэн ажлын үр дүн гэж бодож байна.

-Таны бодлоор Монголын хүний нөөцийн салбарт юу дутагдаж байна вэ?

-Монголын өнөөгийн эдийн засаг, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын үйл явцад хүнд оруулах хөрөнгө оруулалт орхигдож болохгүй юм. Хүнд оруулах хөрөнгө оруулалт гэдэг нь тухайн мэргэжил, ажилдаа дадсан, биеэ даах чадвартай болоход нь мэдлэг болох чадваржуулах мэдээллийг хүргэх, сургах үйл явц. Ямар ч нарийн тоног төхөөрөмж, барилга, техник байгаад түүнийг ажиллуулах мэдлэгтэй хүн байхгүй бол үнэ цэнэгүй, үр ашгийг нь үзэж чадахгүй. Энэ бол Монголд дутагдаж буй зүйл. Хөгжлийн хурд маш хурдан байна. Монгол хүмүүсийн боловсролын түвшин сайжирч байгаа ч эдийн засгийн хурдаа гүйцэхгүй хэмжээнд хүрчихлээ.

Нийгэмд шаардлагатай хүмүүс нь бүрэн боловсорч чадахгүй байна. Техник, технологиосоо хоцрогдож байна. Өөр нэг дутагдаж байгаа зүйл нь хувь хүнтэй холбоотой ур чадвар, дадлууд. Ялангуяа их, дээд аль ч сургуульд суралцаад олж чаддаггүй тийм чадварууд. Тухайлбал, мужаан олон байгаа ч ширээг чанартай хийдэг чадвартай мужаан олно гэдэг танай улсын хувьд хэцүү болчихоод байна.

-Таны болон танай байгууллагын ирээдүйн зорилго юу юм бэ. Дэлхийн хэмжээний зөвлөх үйлчилгээний байгууллага болох уу?

-Би мөрөөдөгч биш. Дэлхийн хэмжээнд хүрч, олон хүнд үйлчлэхийн тулд бүтцийн хувьд том, олуулаа байх шаардлагагүй гэж боддог. Харин тухайн хүмүүст өгч байгаа мэдээлэл, заах арга, агуулга маань л өргөн цар хүрээтэй, дэлхийн хэмжээнд байх ёстой. “Хэрвээ та одоо байгаа байдлаа хадгалж үлдэхийг хүсэж байгаа бол байнга өөрчлөгд” гэсэн зарчим байдаг. Тоо, хэмжээ чухал бус агуулга, арга зүй л нэгдүгээрт байх ёстой. Хамгийн чухал нь тухайн хүнд, хэсэг бүлэгт өгч буй мэдээллээ өөрөө өгч, үр дүнг нь мэдрэх. Бид дарга, ажлын үр дүн шалгагч, үүрэг даалгаврын биелэлтийг хянагч биш өөрийн гараар, нүдээр бусдыг мэдлэгжүүлэх, хамтран хөгжихийг илүүд үздэг.

-Таныг морь унаж, ойгоор зугаалж, ан хийх дуртай гэсэн. Тэр ч бүүхэл, нум сум харвадаг гэж байсан?

-Тийм ээ. Энэ бол миний үнэнч хоббинууд. Гэхдээ би энэ бүгдийг Монголд ирэхээсээ өмнө хийдэг байсан юм шүү. Харин хожим нь Монголыг олсон. Эхнэр бид хоёр арван жилийн өмнө гэр бүл болж, одоо хоёр хүүгийнхээ хамт Хамбург хотод амьдарч байна. Би модны инженер мэргэжилтэй. Хэдийгээр эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаагүй ч би одоо хийж байгаа ажлаа хийх л гэж тэр мэргэжлээр суралцаж төгссөн. Миний гадаад төрх, зарим үйлдэл герман боловч амьдралын хэв маяг, гэр бүлийн уур амьсгал гээд бүх зүйл монгол гэж хэлж болно. ■

www.mongolianeconomy.mn



Утас: 976 - 7011 5476

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

САЙН ЗАСАГЛАЛЫН ХӨРС ТУЗ



Б.УУГАНБАЯР

...Шинэ хуулийн заалтыг хэрэв компаниуд хэрэгжүүлж чадах юм бол сайн засаглалын жишигт нийцэхээр ТУЗ-тай болох аж. Ингэснээр ТУЗ нь компанийнхаа ирээдүйд учирч болох эрсдэлийг тооцож, хяналтын тогтолцоогоо сайжруулж, удирдлагын зүгээс гарч буй шийдвэрийг нягталж, алсын хараатай бодлого явуулах үндэс бүрдэх юм...

Компанийн сайн засаглал нь хувьцаа эзэмшигч, удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хамтын ажиллагаа, зохистой харилцаанаас тогтдог аж. Тэгвэл аливаа компанийн ашиг орлоготой, урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах эсэх нь ТУЗ-өөс шууд хамааралтай. Нэг ёсондоо

ТУЗ нь компанийнхаа бодлогын стратеги төлөвлөгөөг боловсруулж, хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалах, удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг голлон хийдэг. Ашиг орлого өндөртэй, нэр хүнд сайтай, дэлхийн томоохон бизнес эрхлэгчдийн нууц нь ТУЗ-өө сайн бүрдүүлж чадсанд байдаг

гэдгийг судлаачид хэлдэг.

Гэтэл манайд хувьцаат компани бүрт ТУЗ гэсэн орон тоо бий ч билгэдэл төдий байдаг. Өнгөрсөн жил Компанийн тухай хуулийг шинэчлэн найруулснаар ТУЗ-ийн үүрэг хариуцлага, бүтцийг нарийвчлан зааж өгсөн нь сайн хэрэг. Шинэ хуулиар ТУЗ-ийн үүрэг хариуцлага, хийх ажлыг нь маш тодорхой болгосон гэж холбогдох албаныхан ярьдаг. Ингэхдээ ТУЗ-ийн нийт гишүүдийнх нь 1/3 нь хараат бус гишүүн байхаар заасан. Тэднийг Аудитын, Нэр дэвшүүлэх, Урамшууллын гэсэн гурван дэд хороонд хамааруулж ажиллуулахаар тусгасан. Өөрөөр хэлбэл, хий хоосон нэр зүүчихээд, хийх ажлаа мэдэхгүй, ямар ч үүрэг хариуцлагагүй явдаг байсан ТУЗ-ын нөхдүүд дороо гурвын гурван дэд хороотой болчихож буй юм. “Гэвч бодит байдал дээр компанийн захирлууд засаглалаа бэхжүүлэх, ТУЗ-өө зөв бүрдүүлэхийн ач тусыг ойлгохгүй байгаагаас компанийнхаа нэр хүнд, ашиг орлогыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт татаж чадахгүй байна” гэдгийг Компанийн засаглалын хөгжлийн төвийн тэргүүн Ж.Үнэнбат шүүмжилсэн.

Шинэ хуулийн заалтыг хэрэв компаниуд хэрэгжүүлж чадах юм бол сайн засаглалын жишигт нийцэхээр ТУЗ-тай болох аж. Ингэснээр ТУЗ нь компанийнхаа ирээдүйд учирч болох эрсдэлийг тооцож, хяналтын тогтолцоогоо сайжруулж, удирдлагын зүгээс гарч буй шийдвэрийг нягталж, алсын хараатай бодлого явуулах үндэс бүрдэх юм. Гэтэл тус хуулийн заалтыг цаасан дээр хэрэгжүүлж ▶

► буй нь харамсалтай. Монголын компаниудын ТУЗ-ийг олон улсын байгууллагын зарим нь “Гараа өргөгч”, “Тамгалагч”, “Нэг ангийн”, “Алдар цуутны”, “Гэр бүлийн”, “Хий үзэгдэл” хэмээн нэр хоч зүүж амжсан байдаг гэнэ. Энэ нь хэдий инээдтэй сонсогдож буй ч бодит байдал дээр манайд ТУЗ сул дорой, эрх мэдэл нь нэг хүнд төвлөрсөн, шийдвэр нь эзнээс шууд хамааралтай байгааг харуулж байна. Мөн Монголын нийт хувьцаат компаниудын 80 орчим хувийг гэр бүлийн засаглалтай компани эзэлж буйг Үнэнбат онцолсон. Гэхдээ сайн засаглалын үр ашгийг мэдэрч, ойлгоод эхэлчихсэн байгууллага, компани ч цөөнгүй бий. Тухайлбал, “Ньюком”, АПУ, ХААН, Хас банк зэрэг компанийн ТУЗ сайн ажиллаж, компанийн засаглалыг ном ёсоор хөгжүүлж, зөв яваагаас яагаад суралцаж болохгүй гэж.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Б.Даажамба “Манай дотоодын компаниуд өсөж дэвжихгүй, гадаадын хөрөнгө оруулалттай компанид өөрсдийн зах зээл, чадварлаг боловсон хүчнээ алдаад байгаагийн гол шалтгаан нь компанийн засаглал муу байгаатай шууд холбоотой” гэв. Өөрөөр хэлбэл, Компанийн тухай шинэ хуулиа мөрдөж, ТУЗ-ийн ил тод байдлыг хангаж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчноо бүрдүүлэхгүй байгаа гэсэн үг. Тиймээс ТУЗ-ийнхөө бүтцийг хуулийн дагуу зохион байгуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүй 20 орчим компанийн эрхийг өнгөрсөн долдугаар сард түдгэлзүүлсэн аж. Түүнчлэн манай компаниуд засаглал сайтай бол дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргаж, ашиг орлогоо нэмэгдүүлэх бүрэн боломжтой.

Засаглалаа сайжруулахыг цаг үе шаардаж, засаглал муутай нь бизнесийн өрсөлдөөнд шахагдаж, хөрөнгө оруулалт, нэр хүндээ алдсаар. Тэгэхээр сайн засаглалыг бүрдүүлэх хөрс нь болж өгдөг ТУЗ-өө хууль дүрмийнхээ дагуу зөв бүтэцтэй зохион байгуулж, ирээдүйгээ харсан алхам хийхийг компаниуддаа уриалъя. ■

САЙН ТУРШЛАГА

“БЭРЭН МАЙНИНГ” КОМПАНИЙН ЗАСАГЛАЛТАЙ ТАНИЛЦ



1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

Есөн гишүүнтэй /түүнээс гурав нь хараат бус гишүүн/

2. Гүйцэтгэх захирал

Бэрэнбаралын Мөнхдалай

1986-1990 Багануурын уурхай, Холбоо техникийн албаны дарга

1990-1996 “Бэрэн” ХХК-ийн инженер

1996-2006 “Бэрэн констракшн” ХХК-ийн ерөнхий захирал

2006 оноос өнөөг хүртэл “Бэрэн майнинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал

3. Гол бизнес

Төмрийн хүдэр олдворлох, баяжуулах, ангижруулах үйлдвэр. Жилд нэг сая тонн төмрийн хүдэр баяжуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

4. Хувьцаа эзэмшигчдийн тоо

Манай компани хөрөнгийн зах зээл дээр IPO гаргахаар судалж буй учир одоогоор хувьцаа гаргаагүй байгаа. Архангай аймгийн Хотонт суманд байршилтай 80 сая тоннын нөөцтэй төмрийн хүдрийн орддоо тулгуурлаж, Монголын хөрөнгийн зах зээлээс 130 тэрбум төгрөг босгохоор ажиллаж байна.

6. ТУЗ болон Хувь нийлүүлэгчдийн хурлаа хуралдуулдаг зарчим

Хувь нийлүүлэгчид болон ТУЗ-ийн хурлаа зохион байгуулахдаа гишүүдийнхээ саналыг авч, урьдчилан нэгтгээд, компанийн үйл ажиллагаа, томоохон хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг хэлэлцдэг. Ноогдол ашиг хуваарлихдаа хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансаар дамжуулж, нэгдсэн журмаар тараадаг.

7. ТУЗ-ийн гишүүд боловсролоо дээшлүүлэхэд хэрхэн анхаардаг вэ?

Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдээ засаглалын сургалтад суулгаж, гэрчилгээжүүлсэн.

8. Компанийн засаглалаа сайжруулах чиглэлээр хийж буй шинэчлэл

Компанийн засаглал Монголд хэдийгээр шинэлэг ойлголт ч бид дотоод засаглалаасаа эхлээд хэрэгжүүлэхээр зорьж байна.

10. Компанийн засаглалыг Монгол улсад хөгжүүлэхэд юуг анхаарах ёстой вэ?

Юун түрүүнд компаниуд засаглалаа бэхжүүлэхийн үр шимийг ойлгох хэрэгтэй. Түүнчлэн Компанийн засаглалын нэгдсэн холбоог засаглалаа сайн бэхжүүлж чадсан компанийн төлөөлөл болон холбогдох мэргэжилтэн, судлаачдыг оролцуулан байгуулах хэрэгтэй. Ингэснээр тогтмол хоорондоо мэдээлэл солилцох, туршлагаа хуваалцах, өрсөлдөх боломж бүрдэх юм.